



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР



ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН  
УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2019

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2019 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Хянасан:

Эмхэтгэсэн:

Тайлан гаргасан:

Р.Ганхуяг – ЗУХАГ-ын дарга

П.Баянтүмэн – КХ-ийн дарга

Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Х.Оюунбаяр - КХ-ийн ахлах мэргэжилтэн

Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

С.Ганцэцэг – ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн

Л.Батчимэг - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн

Ж.Баянмөнх – КХ-ийн мэргэжилтэн

С.Өлзийбуян - КХ-ийн мэргэжилтэн

Э.Чинзолбоо - КХ-ийн мэргэжилтэн

Д.Түмэндэмбэрэл- КХ-ийн мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг – ССМХ-ийн мэргэжилтэн

Б.Отгонгэрэл – ГЗБХ-ийн мэргэжилтэн

## АГУУЛГА

ОРШИЛ.....	3
1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	4
1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн томоохон ажлууд.....	4
1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чиглэлээр. ....	4
1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр. ....	6
1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр. ....	10
1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөцийн судалгаа .....	22
1.3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт.....	35
1.4. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа.....	38
1.5. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал.....	40
1.6. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан.....	43
1.7. Газрын зах зээлийн тойм.....	46
1.8. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан.....	55
1.9. КАДАСТРЫН ХЭМЖИЛТ, ЗУРАГЛАЛЫН ТАЙЛАН .....	60
1.10.....Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2019 оны төлөвлөгөө.....	61
1.10.1. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт .....	61
1.10.2. 2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө /улсын хэмжээнд/ .....	72
1.11. Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж буй газрын тайлан .....	73
2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН.....	75
2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/ .....	75
2.1.1. Хөдөө аж ахуйн газар .....	76
2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар .....	79
2.1.3. Зам, шугам сүлжээний газар.....	80
2.1.4. Ойн сан бүхий газар .....	81
2.1.5. Усны сан бүхий газар.....	82
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ-4/.....	83
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/.....	88
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/.....	92

2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/ .....	96
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/ .	101
2.7. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт /Маягт ГТ-8/ .....	106
2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /Маягт ГТ-9/ .....	112

## ОРШИЛ

Монгол Улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган Улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол Улсын Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан байдаг.

Тухайн заалтын дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас аймаг, нийслэлийн 2019 оны газрын нэгдмэл сангийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-9 маягтын дагуу нэгтгэн улсын нэгдсэн тайланг нэгтгэн гаргалаа.

Газрын нэгдмэл сангийн Улсын нэгдсэн тайлан нь тайлангийн хугацаанд газрын нэгдмэл сангийн ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрийн өөрчлөлтийг гаргах, өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой юм.

## 1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

### 1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

#### 1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чиглэлээр.

##### Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн цахим систем

Үндэсний аудитын газрын Нийслэлийн аудитын газраас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Замын-Үүд чөлөөт бүс, Алтанбулаг чөлөөт бүс, Цагааннуур чөлөөт бүс болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ, Газрын алба, Газрын даамал зэрэг газрын харилцааны чиглэлийн байгууллага, албан тушаалтны 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны газар олголт, ашиглалттай холбогдох үйл ажиллагааг хамруулан, тухайн байгууллага, албан тушаалтны энэ талаар гаргасан шийдвэр, нэгж талбарын хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн шалгасан. Тус аудитын тайланд “Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2-т зааснаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэн, газрын төлөв байдал, нөөц, чанарын өөрчлөлтийг тодорхойлох, газар эзэмшигч, ашиглагчийн бүртгэлийг эрхлэх зорилго бүхий газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан, сүлжээг орчин үеийн техник, технологид тулгуурлан бий болгох чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.” гэж дүгнэсний дагуу Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зарим арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас салбарынхаа хэмжээнд “Иргэн төвтэй, ил тод, ухаалаг, газрын харилцааны жил” болгон зарлаж, газрын харилцаанд “Цахим систем”-ийг /цахим засаглал/ нэвтрүүлж “Газрын шинэтгэл” хийх ажлын суурь нөхцлийг хангаад байна.

Улсын хэмжээнд ажиллах Вебэд суурилсан “Газар зохион байгуулалтын болон хот байгуулалтын төлөвлөгөөний”, “Газрын цахим биржийн”, “Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн КАМА”, “Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн”, “Улсын газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээний” цахим мэдээллийн системүүдийг хөгжүүлж, тэдгээрийг “ХУР” болон “ДАН” системд холбож хэрэглээнд гаргаад байна.

Улсын хэмжээнд газрын бүртгэлийн албан ёсны нэгдсэн нэг мэдээллийн системтэй болох, газрын харилцаатай холбоотой бусад салбарын үйл ажиллагааг уялдуулах асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын

сайдаас санаачлан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем нь газрын харилцааны бүхий л асуудал зөвхөн газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжин хэрэгжих нөхцлийг бий болгох бөгөөд улмаар газрыг төлөвлөлтгүй, эмх замбараагүй олгож, газрын зөрчил, маргаан үүсгэж иргэдийн эрх ашгийг хохироох асуудлыг эцэслэж, салбар хоорондын уялдаагүй байдлаас үүдсэн давхардсан төлөвлөлт, үргүй зардлыг бууруулж, газарт оруулж буй хөрөнгө оруулалтыг илүү эрсдэлгүй, баталгаатай болгож байгаа юм. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг ашиглан хөдөө аж ахуй, байгаль орчин, хот байгуулалт, үйлдвэр уурхай, зам, шугам сүлжээ, батлан хамгаалах зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын төрийн байгууллагууд хамтран орон зайн хувьд давхардалгүй, харилцан уялдаатай нэгдсэн төлөвлөгөө хийх бүрэн боломжтой.

Барилга, хот байгуулалтын яамнаас Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг тус тус батлуулж, хуулиудын төслийг боловсруулаад байна.

Энэхүү мэдээллийн систем нь Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, тэдгээрийн оролцоонд түшиглэсэн болгож байгаагаараа онцлог юм.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Улс, аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, нийслэл сум, дүүргийн Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бусад салбарын орон зайн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаарх мэдээлэл, зураг төслөөр иргэд, олон нийтэд үйлчлэх, тэдний саналыг авч оролцоог хангах.

Энэхүү систем нь зам шугам сүлжээ, инженерийн барилга, байгууламж, үйлдвэр уурхай, хөдөө аж ахуйг хөгжүүлэх газрын байршил гэх мэт улс орны ирээдүйн хөгжлийн чиг хандлагын талаарх мэдээллийг улсын хэмжээнд авахаас гадна, өөрийн амьдарч буй орчныг сайжруулах, гэр бүлийн болон бизнесийн зорилгоор газар эзэмших, өмчлөх, ашиглах зэрэг санал хүсэлтээ бүх төрлийн интернэтэд холбогдох боломжтой төхөөрөмжөөр дамжуулан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, кадастрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулах боломжийг нээж байгаа юм.

Мөн түүнчлэн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөний цахим системийг ашиглан хөдөө аж ахуй, байгаль орчин, хот байгуулалт, үйлдвэр

уурхай, зам, шугам сүлжээ, батлан хамгаалах зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын төрийн байгууллагууд хамтран орон зайн хувьд давхардалгүй, харилцан уялдаатай нэгдсэн төлөвлөгөө хийх бүрэн боломжтой.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөний цахим системд [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) хаягаар хандан мэдээлэл авч, саналаа өгөх боломжтой. Үүний тулд эхлээд ДАН системээр дамжуулан нэвтрэх бөгөөд хайлтын хэсгээс саналаа өгөх газрын байрлаж буй аймаг, нийслэл, сум, дүүргийн төлөвлөгөөний төрлийн хамт сонгож тухайн байршилтай холбоотой бусад төлөвлөгөө, газар ашиглалтын мэдээлэлтэй уялдуулан газрыг эзэмших, ашиглах, өмчлөх, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр саналаа өгөх боломжтой болсон байна.

### 1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.

#### Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажил

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад суурь мэдээлэл болгох зорилгоор бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

“Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлыг 2015 оноос эхлэн Швейцарийн хөгжлийн агентлаг Ногоон-Алт төсөлтэй хамтран хэрэгжүүлж байгаа юм.

2019 онд улсын хэмжээнд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын газрын даамлуудын оролцоотойгоор нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 314 сумын 109.2 сая га талбайг төлөөлүүлэн 4781 мониторингийн цэгт хийсэн байна /Хүснэгт 1.1.2.1/.

Хүснэгт 1.1.2.1: Бэлчээрийн мониторингийг төлөөлж буй талбайн хэмжээ.

№	Аймаг	Сумын тоо	Мониторингийн нийт цэгийн тоо	Төлөөлж буй талбайн хэмжээ /га/	Бэлчээрийн газар /га/
1	Архангай	18	381	3,742,769.0	3,737,619.6
2	Баянхонгор	19	296	7,189,585.0	8,859,008.9
3	Баян-Өлгий	12	225	3,088,889.0	3,538,667.8
4	Булган	14	164	2,330,623.0	2,484,669.0




5	Говь-Алтай	18	311	8,334,315.2	8,608,957.2
6	Говьсүмбэр	3	43	3,409,462.7	469,568.3
7	Дархан-Уул	3	25	174,689.2	176,934.4
8	Дорнод	13	253	8,178,123.0	8,651,643.8
9	Дорноговь	14	208	8,978,538.2	9,157,648.1
10	Дундговь	15	226	7,111,602.1	7,146,790.4
11	Хэнтий	18	301	5,081,653.0	5,068,198.9
12	Ховд	16	204	5,325,936.0	5,064,435.0
13	Хөвсгөл	23	408	3,652,746.2	4,380,038.5
14	Сэлэнгэ	17	96	1,092,108.0	1,611,780.7
15	Сүхбаатар	13	183	8,111,259.0	7,668,897.5
16	Төв	23	236	4,927,875.5	5,180,040.9
17	Өмнөговь	15	177	10,137,244.3	11,428,851.0
18	Увс	19	349	6,175,046.0	4,287,389.5
19	Завхан	21	388	6,434,502.8	6,925,216.6
20	Орхон	2	7	20,725.0	39,364.7
21	Өвөрхангай	18	283	5,572,130.0	5,690,032.2
22	Улаанбаатар	6	17	196,614.5	210,679.6
<b>ДҮН</b>		<b>320</b>	<b>4781</b>	<b>109,266,437</b>	<b>110,386,433.0</b>

Бэлчээрийн төлөв байдал: 2018 оны бэлчээрийн газрын төлөв байдал, мониторингийн үр дүнг 2019 оны үр дүнтэй харьцуулахад бэлчээрийн төлөв байдлын доройтлын зэрэглэл нэмэгдсэн байна /Хүснэгт 1.1.2.2/.

*Хүснэгт 1.1.2.2: Бэлчээрийн доройтлын ангиллын хувь*

№	Бэлчээрийн доройтлын ангилал	2018 оны дүн (хувиар)	2019 оны дүн (хувиар)
1	I-Байгалийн унаган төрхөө алдаагүй	24	17
2	II - бага зэрэг доройтсон	40	35
3	III - Дунд зэрэг доройтсон	20	22
4	IV- Хүчтэй доройтсон	12	21
5	V - Маш хүчтэй доройтсон	5	5
<b>Нийт хувь</b>		<b>100</b>	<b>100</b>

Өөрөөр хэлбэл бэлчээрийн соргог төлөв, бага доройтлыг илэрхийлж буй 1 ба 2 дугаар түвшингийн үзүүлэлт 2019 онд буурсан байхад дундаас маш хүчтэй доройтсон төлөвийг илэрхийлж буй 3 ба 4 дугаар түвшингийн үзүүлэлт өссөн байна.



Зураг 1.1.2.1: Бэлчээрийн төлөв байдал /2019 оны байдлаар/.

2019 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 17.0 сая га талбай байгалийн унаган төрхөө алдаагүй, 40.5 сая га талбай бага зэрэг доройтсон, 21.1 сая га талбай дунд зэрэг доройтсон, 24.1 сая га талбай хүчтэй доройтсон, 4.7 сая га талбай маш хүчтэй доройтсон дүн гарсан байна.

**Бэлчээрийн даац:** 2019 оны байдлаар улсын хэмжээнд бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр 77 сая мал 2019-2020 онуудад өвөлжиж, хаваржих боломжтой байна /Хүснэгт 1.1.2.3/.

Хүснэгт 1.1.2.3: Бэлчээрийн даац, аймгуудаар

№	Аймаг	Тэжээлийн нөөц, тн	Хонины идэх өвс, кг	Өвөл, хаврын бэлчээрийн даац /хонин толгой/	Малын тоо /хонин толгой/, 2018 он	Зөрүү
1	Архангай	922,016	320	2,530,738	10,714,029	-8,183,291
2	Баян-Өлгий	639,662	308	1,706,014	3,448,137	-1,742,122
3	Баянхонгор	1,352,605	273	4,858,115	6,485,684	-1,627,569
4	Булган	402,190	320	1,133,632	5,948,871	-4,815,240
5	Говь-Алтай	1,011,508	204	3,557,929	4,674,814	-1,116,885
6	Говьсүмбэр	137,395	273	447,579	606,910	-159,331
7	Дархан Уул	49,477	320	146,502	623,816	-477,314
8	Дорноговь	979,861	273	3,643,838	3,466,264	177,574
9	Дорнод	4,352,880	273	11,240,609	5,220,372	6,020,237
10	Дундговь	949,965	273	3,226,089	5,169,516	-1,943,427
11	Завхан	1,732,413	308	5,027,323	5,817,335	-790,012
12	Орхон	6,941	320	30,344	266,231	-235,886
13	Өвөрхангай	872,943	273	2,578,840	8,665,943	-6,087,103

14	Өмнөговь	1,041,354	204	4,659,835	3,752,014	907,821
15	Сүхбаатар	2,367,889	273	7,660,095	6,851,191	808,904
16	Сэлэнгэ	721,123	320	2,259,390	3,159,690	-900,300
17	Төв	1,976,432	273	6,667,241	7,905,703	-1,238,462
18	Увс	852,255	273	2,528,095	4,805,641	-2,277,546
19	Ховд	1,226,723	308	2,727,578	4,824,995	-2,097,417
20	Хөвсгөл	1,717,781	320	4,207,455	9,483,958	-5,276,503
21	Хэнтий	2,212,985	320	6,167,799	8,179,159	-2,011,360

2018 оны жилийн эцсийн байдлаар малын тоо 110 сая хонин толгой байгаа ба энэ нь боломжит даацаасаа 33 сая хонин толгойгоор хэтэрсэн байна. 2019 онд Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Дорноговь аймгуудын хувьд бэлчээрийн даац хэтрээгүй, бусад аймгуудын хувьд бэлчээрийн даац хэтэрсэн байна.

**Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээ байгуулах ажил**

Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээ байгуулах” гэрээт ажлыг 2008 оны 10 дугаар сараас эхлэн “АТТП” ХХК хийж гүйцэтгэж байна.


Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үндэсний сүлжээ нь газрын харилцааны салбарын оролцогч талуудыг нийт нутаг дэвсгэрийг хамарсан өгөгдөл мэдээлэл, нэгдсэн арга зүйгээр хангах, харилцан мэдээлэл солилцож газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг илрүүлэх, үнэлэх, доройтлоос урьдчилан сэргийлэх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх зэрэг цогцолбор үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үндэсний сүлжээний өгөгдөл мэдээллийг цуглуулах байнгын ажиглалтын талбар болон цэгүүдийг байгуулахдаа:

- Геологийн тогтоц;
- Газрын доорх болон гадаргын ус;
- Хотгор гүдгэр;
- Хөрс;
- Ургамал;
- Уур амьсгал;
- Газрын нэгдмэл сангийн ангилал зэрэг байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийг харгалзсан болно.

Мөн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний сүлжээ байгуулах ажлын хүрээнд төрийн өмчийн болоод иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтөд үзүүлэх хүний болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөллийг богино хугацааны давтамжтай тодорхойлж, түүнд тохирсон газар зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой авч хэрэгжүүлэх, бусад газрын харилцааны цахим системүүдтэй уялдаж ажиллах цахим систем байгуулагдлаа.

Энэхүү цахим систем нэвтэрснээр Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, журмыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй дараах асуудлуудыг шийдвэрлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнд:

- Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь заалтад “Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана” гэж заасан хэдий ч улсын болон орон нутгийн төсвийн байдлаас хамааран дээрх ажил хугацаандаа бүрэн хийгдэхгүй, төрөөс газрын нэгдмэл сангийн нийт газарт газрын төлөв байдал, чанарт хяналтыг бүрэн тавьж чадахгүй байсаар байна;
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газартаа газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэн ерөнхий шинжээч болон байнгын шинжээчээр дүгнэлт гаргуулахад олон үе шат, дамжлагатай, судалгааны тайлан, цаасан материал ихээр боловсруулагдаж байгаа нь төрийн үйлчилгээ хурдан шуурхай, ил тод, нээлттэй явуулахад хүндрэл үүсгэдэг;
- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн үйл ажиллагаа цогц, уялдаатай хийгддэггүй, хээрийн судалгааны объект болон мониторингийн цэг, талбар сонгох үйл ажиллагаа болон хөрсний дээж авах цэг, чанарын шинжилгээний үр дүнгийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, иргэд, олон нийтийг нэгдсэн мэдээллээр хангах мэдээллийн дэд бүтэц байхгүй зэрэг хүндрэлтэй асуудлууд шийдвэрлэгдэх юм.




Зураг 1.1.2.2: Мониторингийн системийн зохион байгуулалт

### 1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.

#### Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем

21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын Газрын бүртгэл, зураглалыг засварлаж, нэгдсэн стандартад оруулж, цаасан хувийн хэргийг материалыг тоон хэлбэрт шилжүүлж, байрлалд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг Улсын хэмжээнд хэмжээнд нэвтрүүлээд байна.

Тухайн системийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр газрын бүртгэл, зураглалын алдааг бүрэн засварлаж, цаасан хувийн хэргийн материалыг цэгцлэх, цахимжуулах ажлыг хийж, нэгдсэн санд бүртгэж баталгаажуулсан бөгөөд газрын харилцааны салбарын албан хаагчдын хийж буй газрын бүртгэл нээлттэй, шат бүрд хяналттай болж, шийдвэр гаргагч нарыг бодит агшны мэдээллээр хангах боломжтой болсон юм.



*Зураг 1.1.3.1: Газрын кадастрын нэгдсэн систем*

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн нэгдсэн нэг стандарттай мэдээлэл бүхий систем байгуулагдаж, Монгол Улсын хэмжээнд нэгдсэн сүлжээнд холбогдож, аймаг, сумын Газрын кадастрын мэдээллийн санд орж буй өөрчлөлт, шинэчлэлтийн ажил ГЗБГЗЗГ-т байрлаж буй нэгдсэн системд орж, нөөцлөгдөх боломжтой болсон.
- Газрын кадастрын мэдээллийн сангийн програм хангамж нь нийт 40 гаруй төрлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, 61 гаруй төрлийн тайлан мэдээ гарах, 15 гаруй төрлийн хяналт шалгалтыг автоматаар хийх болон Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголт хийх, өргөдлийг хүлээн авсан хугацааны дагуу шийдвэрлэх гэх мэт олон боломжийг бүрдүүлсэн Газрын кадастрын мэдээллийн сангийн цогц систем юм.

- Газрын кадастрын мэдээллээр үйлчлэх боломж бүхий нэгдсэн мэдээллийн сангийн програм хангамжтай болж иргэд интернет ашиглан газрын харилцаатай холбоотой мэдээллийг авах, өргөдөл шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг, өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын талаарх мэдээллийг тус тус харах боломжийг бүрдүүлсэн.
- Кадастрын нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд бүх албан хаагчдын ашиглаж буй тоног төхөөрөмжийг шинэчлэх, өгөгдлийн санг байгуулах, сервер, хадгалах төхөөрөмжийн нийлүүлэлтийг хийсэн бөгөөд газрын салбарт хийгдсэн томоохон технологийн дэвшлийг бүрдүүлсэн юм.
- Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг бусад байгууллагуудтай холбож, бүхий л сервис үйлчилгээг гаргасан бөгөөд одоогийн байдлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Чөлөөт бүсийн газар тус тус ашиглан нэгдсэн бүртгэлд шилжээд байна.

Улсын хэмжээнд ашиглаж буй Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Байгаль, орчин, аялал, жуулчлал яамны Тусгай хамгаалалтай газар болон Чөлөөт бүсийн газарт нэвтрүүлэв.

Дээрх системийг нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

1. Гурван байгууллагын мэдээллийн сан нэгдэж, нэгдсэн стандартад шилжив.
2. Газрын зөрчил маргааныг илрүүлэн шийдвэрлэх боломж бүрдсэн.
3. Тусгай хамгаалалтай газарт газар олгох үйл ажиллагааны процессыг Дундын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулах боломжтой болсон.
4. Цахимаар хоёр байгууллагууд тухай бүр мэдээллээ солилцох бүрэн боломжтой болсон.

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн нөөц хувилбарыг Үндэсний дата төвд байрлуулан ХУР системд холбож, хэрэглээнд нэвтрүүлэв.

ХУР системд холбогдсоноор дараах үр дүнд хүрсэн. Үүнд:


1. Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох бүрэн боломжтой болсон бөгөөд газартай холбоотой сервис үйлчилгээнүүдийг Дата төвд нэгдсэн стандартын дагуу гаргаж, шууд холбогдох боломжтой болсон;
2. Хурууны хээний төхөөрөмжөөр дамжуулан иргэний бүртгэлийг Газрын кадастрын мэдээллийн санд шууд автоматаар бүртгэх боломжтой болсон бөгөөд иргэдийн мэдээлэл давхцалгүй болсон байна.

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн нөөц хувилбарыг Үндэсний дата төвд байрлуулан ДАН системд холбож, хэрэглээнд нэвтрүүлэв.

ДАН системд холбогдсоноор дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

3. Иргэн, аж ахуйн нэгжүүд орон зай цаг хугацаанаас үл хамааран өөрийн газартай холбоотой буюу кадастрын зураг, гэрээ, гэрчилгээ, захирамж гэх мэдээллүүдийг QR кодоор баталгаажуулан цахимаар авах боломжтой болсон.

4. Газрын кадастрын мэдээллийн сангийн хэрэглээнд Тоон гарын үсгийг нэвтрүүлэв.




Зураг 1.1.3.2: Газрын кадастрын нэгдсэн систем ХУР, ДАН системд холбогдсон байдал

### Газрын бүртгэлийн дундын мэдээллийн сан

Улсын хэмжээнд ашиглаж буй Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Үндэсний дата төвд байрлуулж, ХУР системээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэв.

Дундын мэдээллийн санг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийг Улсын бүртгэлийн газар хянан үзээд Э болон А дугаарыг цахимаар илгээж тухайн дугаарыг гэрчилгээнд тавьж баталгаажуулдаг болсон.
2. Хоёр байгууллагын мэдээллийн сан нэгдэж, байрлалд суурилсан давхцалгүй бүртгэлийг хийх боломжтой болсон.
3. Газрын бүртгэл, баталгаажилтыг хийлгэхийн тулд иргэд, аж ахуйн нэгжүүд хоёр байгууллагын дунд явж, цаг хугацаа их алддаг байсан бол нэг цэгээс буюу Газрын албанаас бүхий л үйлчилгээг авах боломжтой болсон.



Зураг 1.1.3.3: Газрын бүртгэлийн дундын мэдээллийн сан

**Газрын кадастрын мэдээллийн сангийн иргэд олон нийтэд нээлттэй веб систем /[www.egazar.gov.mn/](http://www.egazar.gov.mn/)**

Олон нийтэд зориулсан Газрын кадастрын мэдээллийн сангийн веб системээс иргэн, аж ахуйн нэгж цаг хугацаа, орон зайнаас үл хамааран газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжтой болсон.

Газрын кадастрын мэдээллийн сангийн веб системийг хэрэглээнд гаргаснаар дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- Өргөдлийн хяналт. Иргэн газартай холбоотой гаргасан өргөдлөө хэн гэдэг мэргэжилтэнд, ямар шатандаа шийдвэрлэгдэж байгааг харах боломжтой.
- Эрхийн баталгаажуулалт. Өөрийн газрын мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг харах боломжтой.
- Нэгж талбарын мэдээлэл. Нэгж талбартай холбоотой талбайн хэмжээ, хаяг, байршил зэрэг мэдээллийг харах боломжтой.
- Тухай шатны Засаг даргын шийдвэр, шийдвэрийн дугаар, огноо, гэрээ, гэрчилгээ, түүний дугаарыг тус тус харах боломжтой болсон.
- Төлбөр, татварын мэдээлэл. Газрын төлбөр, татвар хэдэн төгрөг төлөх болон, төлбөрийн үлдэгдэл, данстай холбоотой мэдээлэл харах боломжтой.
- Газрын үнэлгээ, суурь үнэлгээ. Өөрийн газрын Засгийн газраас тогтоосон суурь үнэлгээ болон дуудлага худалдааны анхны үнэ, үнэлгээний бүсчлэлтэй холбоотой мэдээлэл харах боломжтой.
- Тухайн газрын гадаргын өндөршил, гадаргын налуу, сургууль хүртэлх зай, цэцэрлэг хүртэлх зай, эмнэлэг болон тамгын газар хүртэлх зай гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй харах боломжтой.



Дээрх веб системээс гар утас, интернет ашиглан газартай холбоотой бүхий мэдээллийг нээлттэй харах боломжтой болоод байна.



Зураг 1.1.3.4: Газрын кадастрын мэдээллийн сангийн иргэд олон нийтэд нээлттэй веб систем

### Газрын үнэлгээ, татвар төлбөрийн систем

Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох зорилгоор дараах 7 багц ажлыг хэрэгжүүллээ /Зураг 1.1.3.5/.



Зураг 1.1.3.5: Ажлын иж бүрдэл

Дээрх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Газрын үнэлгээ хийх зааврын төслийг боловсруулах

Газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангилал тус бүрээр газрын эдийн засгийн үнэлгээ хийх болон газрын үнэлгээний бүсийн зураг хийх аргачилсан заавруудын төслийг боловсруулж, холбогдох хэлэлцүүлгүүдийг хийж, Газрын даргын 2019 оны А/279 дүгээр тушаалаар батлуулав /Зураг 1.1.3.6/.




Зураг 1.1.3.6: Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачилсан зааврууд

## 2. Газрын үнэлгээний мэдээллийн сан үүсгэх

Газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангилал тус бүрийн газрын үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлс болон газрын зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулж бэлтгэн, мэдээллийн сан үүсгэсэн.

## 3. Газрын төлбөр, татварын зориулалттай Кадастрын үнэлгээний систем (САМА)-ийг хөгжүүлэх

Газрын төлбөр, татварын зориулалттай Кадастрын үнэлгээний систем (САМА)-ийг хөгжүүлэх ажлын хүрээнд Газрын үнэлгээний системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэхүү систем нэгдмэл сангийн 6 ангилал тус бүрийн газрын суурь үнэлгээг үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс, газрын зах зээлийн үнийг ашиглан автоматаар тооцоолох боломжтой юм /Зураг 1.1.3.7/.



Зураг 1.1.3.7: Газрын үнэлгээний системийн нэвтрэх хэсэг

No	Код	Нэр	Томъёо	Тайлбар	Хүчтэй эсэх	Удирдах
1	calculated_market_price	Зах зээлийн үнэ тооцох	$[purchase\_price]-[real\_estate\_price]-[other\_investments]-[other\_price]$	Газрын худалдсан үнээс үл хөдлөхийн үнийг хасах тооцох	Тийм	
2	calculated_price_urban_area	Аймгийн төв, томоохон сумдын хот тосгон бусад суурингийн газрын үнэ тооцох	$13794.3-1.27*bohir-1.07*dukaan-1.17*hospital-3.94*school-1.81*kinder-1.02*road-2.87*center-0.01*angle-1.04*trade$	bohir-армуутах татуургын шугам dukaan-дулааны шугам hospital-эмнэлэг center-сумын төв/ захиргаа/ school-сургууль kinder-цацраг road-авто зам trade-худалдаа, үйлчилгээний төв angle-газрын гадаргын налуу	Тийм	
3	calculated_price_urban_sam	Бусад сумдын хот тосгон бусад суурингийн газрын үнэ тооцох	$2675.1-0.12*center-0.09*school-0.08*kinder-0.13*trade-0.11*angle$	center-сумын төв/захиргаа/ school-сургууль kinder-цацраг road-авто зам trade-худалдаа, үйлчилгээний төв angle-газрын гадаргын налуу	Тийм	
4	calculated_price_water_base	Усны сав бүхий газрын суурь үнэ тооцох	$[surface\_total\_value]*[surface\_price]+[pasture\_base\_price]$		Тийм	

Зураг 1.1.3.8: Газрын үнэлгээний систем

#### 4. Газрын суурь үнэлгээг нэгж талбар бүрээр тогтоох

Газрын үнэлгээний системийг ашиглан улсын хэмжээнд 640000 нэгж талбарын суурь үнэлгээг автоматаар тооцоолж гаргасан.

#### 5. Газрын төлбөр, татвар, хураамжийн орлогын ногдуулалт, гүйцэтгэл, хяналт, тайлагнал, цахим төлбөр тооцооны програм хангамжийг хөгжүүлэх

Газрын төлбөр, татвар тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг ногдуулах, хураах ажлыг хялбарчилсан Газрын төлбөр, татварын системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Өөрөөр хэлбэл 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтнүүд, сумын Газрын даамлууд Газрын төлбөр, татвар тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг автоматаар тооцож ногдуулах, харин газрын төлбөр, татвар, хураамж төлөгч дурын банкны аппликэйшн /интернет банк, мобайл банк, АТМ гэх мэт/-ийг ашиглан хялбар төлөх боломжийг бүрдүүлж байна.

Мөн газрын төлбөр, татвар тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг ногдуулах, хураах ажилд тухай бүр хяналт тавих боломжоор хангагдлаа.

No	Гэрээний дугаар	Регистрийн дугаар	Төлбөр төлөгч	Нэгж талбар	Жил	Гэрээнд ногдуулсан дүн	Хөнгөлөгдсөн дүн	Тухайн жил нийт	Нөхөн төлбөр	Хүү торгууль	Урьд оны илүү, дутуу	Бүгд дүн	Төлөв	Бүртгэсэн өснөг	Удирдах
1	06307-2003/00545	ГД43021078	Г.Зэвжид	6301000342	2019	3000	0	3000		0	0	3000	Нодуулалт үүссэн	2019-09-30 15:19:04	
2	06307-2019/00029	ГД76062271	З.Түвшинэст	6301000628	2019	3000	0	3000		0	0	3000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:52:51	
3	06307-2003/00538	ГД77042378	П.Отгонбаяр	6301000333	2019	3000	0	3000		0	0	3000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
4	06307-2003/00539	ГД73011678	П.Батбаяр	6301000334	2019	3000	0	3000		0	0	3000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
5	06307-2003/00536	3194779	Есөн хусал трейд	6301000700	2019	234	0	234		0	0	234	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
6	06307-2003/00541	ИВ76100613	Б.Баасандорж	6301000357	2019	3000	0	3000		3000	6000	6000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
7	06307-2003/00542	ГД74101478	П.Өрнөхбаяр	6301000338	2019	3000	0	3000		2000	5000	5000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
8	06307-2003/00540	ГО67050776	Д.Эрэнэч	6301000336	2019	3000	0	3000		0	0	3000	Нодуулалт үүссэн	2019-09-19 10:38:55	
9	06307-	ГО68121073	П.Дашбаяр	6301000332	2019	3000	0	3000		0	0	6000	Нодуулалт үүссэн	2019-09-19	

Зураг 1.1.3.9: Газрын татвар, төлбөрийн систем

6.Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх

Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтнүүд, сумын Газрын даамлуудад нийт 3 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 166 мэргэжилтнүүдийг хамруулсан /Зураг 1.1.3.10/.

**СУРГАЛТ 01** 2019.02.19–2019.03.08-ны өдрүүдэд Дорнод, Дархан-Уул, Ховд, Дундговь, Завхан аймгуудад бүсчилсэн сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 20 аймгийн 80 мэргэжилтэн, сумдын Газрын даамлууд оролцсон


**СУРГАЛТ 02** Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй хамтран хөрөнгийн үнэлгээний анхан шатны сертификаттай сургалтыг 2019.04.22–04.30-ны өдрүүдэд зохион байгуулж ГЗБГЗЗГ, 21 аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргүүдийн ГЗБА-ны Газрын үнэлгээ, төлбөр, татварын асуудал хариуцсан 43 мэргэжилтнүүд оролцсон

**СУРГАЛТ 03** 2019.11.11–11.18-ны өдрүүдэд Орхон аймагт Газрын татвар, төлбөрийн систем, Газрын үнэлгээний цахим системийн сургалтыг 21 аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргүүдийн ГЗБА-ны Газрын үнэлгээ, төлбөр, татварын асуудал хариуцсан 43 мэргэжилтнүүд оролцсон.

Зураг 1.1.3.10: Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн системийн талаарх сургалт зохион байгуулсан байдал.

“Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон

нийтэд нээлттэй, ил тод болгох” ажил амжилттай хэрэгжснээр дараах үр дүнд хүрч байгаа юм /Зураг 1.1.3.11/.



*Зураг 1.1.3.11: “Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох” ажлын үр дүн*

### Газрын биржийн цахим систем

Газрын биржийн цахим системийг байгуулах, хөгжүүлэх ажлын зорилго нь газрын арилжаа худалдаанд оролцогчдод газартай холбоотой бүх төрлийн мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлсэн мэдээллийн системийг байгуулж арилжааны танхим нээж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, зах зээлийн үнийн мэдээг улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтад оруулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд чиглэгдсэн юм.

Тухайн ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Газрын биржийн арилжааны танхим байгуулах, тохижуулах, засварлах /Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт/:
2. Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түүх, өнөөгийн байдал, зах зээлийн бүтэц, багтаамж, оролцогч талууд, нөлөөлөх хүчин зүйлс, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, нэгдсэн судалгаа хийх:
3. Газрын биржийн төлбөр, тооцоог бүрэн цахимжуулах, програм хангамжийн хөгжүүлэлт хийх:
4. Програм хангамжид оруулах өгөгдөл мэдээг цуглуулах, засварлах:
5. Газрын биржийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авах:
6. Газрын биржийн цахим системийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, олон нийтэд таниулах:




Зураг 1.1.3.12: Ажлын иж бүрдэл, эзлэх хувь

Тухайн ажлыг хийж гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрч байна. Үүнд:

- Улсын хэмжээний газрын бирж байгуулагдаж үйл ажиллагаанд орно;
- Улсын хэмжээний газрын сан бүрдэж эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагааг нэг цэгт төвлөрнө;
- Газрыг эрэлт хэрэгцээ, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд нийцүүлэн хөгжүүлэлт хийгдэж бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлнэ;
- Газрын дуудлага, худалдаа, төсөл сонгон шалгаруулалт улсын хэмжээнд ил тод зохион байгуулагдаж нэгдсэн зохион байгуулалтанд орно;
- Эрхийн зөрчилтэй газар зарагдах, газрыг зориулалт бусаар ашиглах, төлөвлөлтөд ороогүй газрыг ашиглах, худалдах зөрчил багасна;
- Газрын зах зээлийн үнэ ханш, эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлтийг жигд тогтвортой байлгаж газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ;
- Газраас олох эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдэж улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэн эдийн засгийг эрчимжүүлнэ;
- Газрын худалдаа, арилжааны нэгдсэн мэдээллийн сантай болж, хяналтын тогтолцоо сайжирна;
- Газар дахин төлөвлөлтийн болон гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг эрхлэх боломж бүрдэнэ;
- Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцлийг бүрдүүлж, төвлөрсөн мэдээллээр төр, олон нийтийг хангана;
- Газрын зах зээлийн мэдээллийг нээлттэй ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагаа нэг цэгт төвлөрөх.

Тус ажлын хүрээнд дэлхий дахинд тренд болж буй технологиудын хамгийн сүүлийн хувилбаруудыг ашиглан нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн бөгөөд Кадастрын мэдээллийн сан, Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц болон холбогдох бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдон ажиллах боломжтой болсон.


Шинээр хөгжүүлж буй цахим системийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.



Зураг 1.1.3.13: Газрын цахим биржийн шинэ систем

Шинээр нэвтрүүлж буй систем нь ашиглахад хялбар, энгийн ойлгомжтой бөгөөд иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, Монгол Улсын иргэн өмчилсөн газраа худалдах, худалдан авах үйл ажиллагаанд зуучлах үйлчилгээ үзүүлэх боломжтой болж байгаа юм.


Иргэн, хуулийн этгээд тус цахим системд нэвтэрч Кадастрын мэдээллийн сангаас нэгж талбараа сонгон өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа бусдад худалдах, түрээслэх зараа үнэ, төлбөргүйгээр байршуулах боломжтой болсон. Мөн иргэн, хуулийн этгээд сонирхсон газраа Кадастрын мэдээллийн сан, Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн давхарга мэдээтэй харьцуулж газарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлсэн.



Зураг 1.1.3.14: Газрын цахим биржийн гар утасны аппликейшн

## 1.2. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын Сайдын “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны 22 дугаар тушаалаар баталсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар, Газар зохион байгуулалтын хэлтэс, Геодези, зураг зүйн хэлтэс, Суурь судалгаа, мониторингийн хэлтэс, Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, Хот байгуулалтын хэлтэс, Хот байгуулалтын кадастрын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Архив, мэдээллийн төв гэсэн нийт 10 нэгж, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, дүүргийн газар зохион байгуулалтын алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна /Зураг 1.2.1/.




21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албад, сумдын газрын даамал

Зураг 1.2.1 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бүтэц

Газрын харилцааны салбарт Барилга, хот байгуулалтын яаманд 5, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 86, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 210, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 399, сумдад Газрын даамал 356, нийт 1056 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2/.






Зураг 1.2.2: Улсын хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын тоо


Газрын харилцааны салбарын хэмжээнд Агентлаг, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд ажлаж буй төрийн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг дараах үзүүлэлтүүдээр гаргасан болно.

### Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хүний нөөцийн судалгаа


Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт ажиллаж буй албан хаагчдыг насны 10 үзүүлэлтээр ангилж үзэхэд дийлэнх буюу 21%-ийг 26-30 насны албан хаагчид, 24%-ийг 31-35 насны албан хаагчид, 0.3 %-ийг 56-аас дээш насны албан хаагч эзэлж байна.




Зураг 1.2.3: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчид /насны байдлаар/



Зураг 1.2.4: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын ажилласан жил, төрийн албанд ажилласан жил



Зураг 1.2.5: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын нас, хүйсийн байдлаар



Зураг 1.2.6: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын боловсролын байдал


2020-2025 онд Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдон дагалдан гарсан эрх зүйн баримт бичгийг агентлагийн албан хаагчид, орон нутгийн харьяа байгууллага, газрын мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр тогтмол өгч, салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг удирдан зохион байгуулан ажиллаж ирсэн.

Газрын харилцааны салбарын хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны төрийн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг дараах үзүүлэлтээр гаргасан болно.


### Орон нутагт ажиллагсдын хүний нөөцийн судалгаа

Нийслэлийн газар зохион байгуулалтын алба нь Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/199 дүгээр тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог баталж, тус алба нь 8 хэлтэс, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын алба, нийт 210 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. /Зураг 1.2.7/.




Зураг 1.2.7: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны бүтэц


Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд нийт 210 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.8, 1.2.9/.



Зураг 1.2.8: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны хэлтэс, албан хаагчийн тоо




Зураг 1.2.9: Дүүргийн Газар зохион байгуулалтын албад, албан хаагчийн тоо



Зураг 1.2.10: Нийслэлийн хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн харьцаа


Насны ангиллаар нь авч үзвэл 21-25 насны 17 албан хаагч буюу 7,7%, 26-30 насны 51 албан хаагч буюу 23%, 31-35 насны 39 албан хаагч буюу 17,6%, 36-40 насны 67 албан хаагч буюу 30,3%, 41-45 насны 22 албан хаагч буюу 10 %, 46-50 насны 12 албан хаагч буюу 5,4%, 51-55 насны 11 албан хаагч буюу 5 %, 56-с дээш

насны 2 албан хаагч буюу нийт албан хаагчийн 1 % байна. Үүнээс үзэхэд 36-40 насны албан хаагч хамгийн их буюу 30,3 хувийг эзэлж байна /Зураг 1.2.11/.




Зураг 1.2.11: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын насны ангилал

Ажилласан жилээр нь авч үзвэл нийт албан хаагчдын 37,5% нь төрийн албанд 1-5 жил ажилласан байгаа бол 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа 97 албан хаагч байгаа нь нийт албан хаагчдын 43,9%-ийг эзэлж байна. Мөн төрийн албанд 16-20 жил ажилласан 16 албан хаагч буюу 7,2%, 21-ээс дээш жил ажилласан 25 албан хаагч буюу 11,3%-ийг эзэлж байна. Судалгаанаас харахаад нийт албан хаагчдын 138 албан хаагч буюу 62,8 хувь нь төрийн албанд 6-аас дээш жил ажилласан албан хаагчдаас бүрджээ.



Зураг 1.2.12: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал /ажилласан жилээр/




Зураг 1.2.13: Албан тушаалын ангилал, зэрэглэл

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын 78 буюу 82,3% нь төрийн захиргааны албан хаагч, 32 буюу 17,7% нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.


Төрийн захиргааны албан хаагчид ТЗ-5-аас ТЗ-10 хүртэл албан тушаалын зэрэглэлтэй байна.

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 210 албан хаагчид 100% дээд боловсролтой, үүнээс 170 буюу 80,5% бакалавр зэрэгтэй, 40 албан хаагч буюу 19,5% магистр зэрэгтэй албан хаагчид байна /Зураг 1.2.14/.




Зураг 1.2.14: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын боловсролын түвшин

Газрын харилцааны ажлын байранд шаардагддаг ArcGis, AutoCad, LM програм хангамжийг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын 100% нь дундаас дээд түвшинд эзэмшсэн байна /Зураг 1.2.15/.




Зураг 1.2.15: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын ур чадвар

Гадаад хэлний мэдлэгээр 68 албан хаагч 2 буюу түүнээс дээш хэлний мэдлэгтэй, үүний ихэнх нь англи, орос хэлний хосолсон, нийт албан хаагчдын 52% Англи, 33% Орос хэлийг эзэмшсэн бусад буюу Солонгос, Хятад, Герман, Япон хэлийг 15% нь эзэмшсэн байна /Зураг 1.2.16/.



Зураг 1.2.16: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын хэлний мэдлэг

Албан хаагчдын 61% нь газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхтэй байна. нийслэл, дүүргийн 68% албан хаагч банк, санхүүгийн байгууллагад зээлтэй, 32% нь зээлгүй байна /Зураг 1.2.17/




Зураг 1.2.17: Нийслэл, дүүргийн албан хаагчдын нийгмийн асуудал

### Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрууд

Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”, 276 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл” тус тус шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалтыг агентлагийн даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.


21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ажиллаж байгаа албан хаагчдыг насны байдлаар ангилж үзвэл:

Нийт албан хаагчдын 37% нь 20-30 насны, 41% нь 31-40 насны, 13% нь 41-50 насны, 09 % нь 51-с дээш насныхан байна /Зураг 1.2.18/.




Зураг 1.2.18: Аймгийн газрын харилцаа, барилгаа, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдын насны харьцуулалт

Нийт албан хаагчдын 49% нь эрэгтэй, 51% нь эмэгтэй, албан хаагчдын 85% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.19/.



Зураг 1.2.19: Аймгийн Газрын харилцаа, барилгаа, хот байгуулалтын газрын албан хаагчдын хүйсийн харьцаа болон тухайн орон нутгийн уугуул иргэн эсэх


Аймгийн Газрын харилцааны салбарт 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид хамгийн их буюу 38%-ийг эзэлж байна /Зураг 1.2.20/.



Зураг 1.2.20: Аймгийн Газрын харилцаа, барилгаа, хот байгуулалтын газруудын албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал /ажилласан жилээр/




Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 399 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 78%, Төрийн үйлчилгээний албан хаагч 22% байна /Зураг 1.2.21/.



Зураг 1.2.21: Албан тушаалын ангилал, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй эсэх


Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын 74% нь бакалаврын зэрэгтэй, 15% нь магистрын зэрэгтэй, 11% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой байна.

Бүрэн болон тусгай дунд боловсролтой албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн үйлчилгээний албан үүргийг гүйцэтгэж байна /Зураг 1.2.22/.




Зураг 1.2.22: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын боловсролын түвшин

Ажлын байранд шаардагддаг програм хангамжийг нийт албан хаагчдын 74% нь бүрэн болон сайн эзэмшсэн, давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 283, орос хэлний мэдлэгтэй 127, бусад хэл буюу Солонгос, Япон, Хятад, Герман хэлний мэдлэгтэй 15 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.23/.



Зураг 1.2.23: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын ур чадвар

Нийт албан хаагчдын 47% нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 83% нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.24/.




Зураг 1.2.24: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын нийгмийн асуудал

### Сумын газрын даамлууд


Сумдын газрын даамлуудыг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 253 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Газрын даамлын ангилал, зэрэглэлийг өөрчилж туслах түшмэл /ТЗ-3/-ээс дэс түшмэлийн ангилал, зэрэглэл ТЗ-5-д шилжүүлсэн бөгөөд 21 аймгийн сумдад 356 газрын даамал ажиллаж байгаа бөгөөд ажлын онцлог, сумын нутаг дэвсгэр, хүн амын тооноос шалтгаалж суманд газрын даамал харилцан адилгүй ажиллаж байна.

Сумын газрын даамлуудыг нас болон хүйсээр нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 46 % нь 18-30 насны, 40% нь 31-40 насны, 10 % нь 41 ба түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.25/.




Зураг 1.2.25: Сумын газрын даамлуудын насны ангилал

Сумын газрын даамлуудыг ажилласан жилийг нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 10% нь 1 жил хүртэл, 38% нь 2-5 жил, 44% нь 6-15 жил, 0,7% 16-20 жил бусад 20-оос дээш жил түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.26/.




Зураг 1.2.26: Сумын газрын даамлуудын ажилласан жилийн байдал

Нийт албан хаагчдын 47% нь эрэгтэй, 53% нь эмэгтэй албан хаагчид байгаа ба 88 % нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.27/.




Зураг 1.2.27: Сумын газрын даамлуудын хүйсийн харьцаа, тухайн орон нутгийн уугуул иргэд эсэх

Газрын даамлуудын төрийн албанд 36% нь 2-5 жил, 34% нь 6-15 жил, 34% нь ажиллаж байна /Зураг 1.2.28/.




Зураг 1.2.28: Сумын газрын даамлуудын ажилласан жил

Нийт ажилчдын 98% бакалаврын зэрэгтэй, 1% нь магистрын зэрэгтэй, 1% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.29/.



Зураг 1.2.29: Сумын газрын даамлуудын боловсролын түвшин


Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 291 буюу 77% хувь нь, орос хэлний мэдлэгтэй буюу 21% хувь нь бусад хэлний мэдлэгтэй 1% хувь буюу 5 газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.30/.



Зураг 1.2.30: Сумын газрын даамлуудын хэлний түвшин болон програм хангамж эзэмшсэн түвшин

Сумдын газрын даамлууд ажлын байранд шаардагдах програм хангамжийг тодорхой хэмжээгээр эзэмшсэн ба үүнээс 21 нь бүрэн, 251 нь сайн, 84 нь дунд хэмжээгээр эзэмшсэн байгаагаас харахад цаашид улам газар зүйн мэдээллийн системийн чиглэлээр програм хангамжийг эзэмшүүлэх, мэргэшүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.


Нийт албан хаагчдын 181 нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 282 нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.31/.



Зураг 1.2.31: Сумын газрын даамлуудын нийгмийн асуудал


### 1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2019 онд 21 аймгийн хэмжээнд газрын талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд давхардсан тоогоор нийт 903 удаагийн хяналт, шалгалт хийснээс нийт 12750 зөрчил илэрсэн байна /Зураг 1.3.1/.



Зураг 1.3.1. 2019 онд газрын харилцааны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо болон илэрсэн зөрчлийн тоо /аймаг тус бүрээр/

Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо, хэмжээ улсын хэмжээнд 2016 оноос эхлэн жил дараалан буурсан үзүүлэлттэй байсан бол 2019 онд өссөн үзүүлэлттэй байна /Зураг 1.3.2/.




Зураг 1.3.2. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн тоо 2016, 2017, 2018, 2019 он

2019 онд Завхан, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ, Булган аймгууд газрын талаар хууль тогтоомжид хяналт, шалгалтыг хамгийн олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумдаа хамруулж 79-154 удаа явуулсан байна /Зураг 1.3.3/.


Харин Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон зэрэг цөөн тооны сумтай аймгууд хамгийн бага давтамжтай буюу 3-6 удаа хяналт шалгалтыг явуулжээ.

Орон нутагт хийсэн хяналт, шалгалтын ажлын давтамжаас хамаарч илэрсэн зөрчлийн тоо харилцан адилгүй байна.



Зураг 1.3.3. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо


2019 онд Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар нийт 12750 зөрчил илэрсэн байна. Үүний 10329 буюу 88% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 1281 буюу 11% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил эзэлж байгаа бол 125 буюу 1% нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.4/.



Зураг 1.3.4. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, түүний харьцуулалт

2019 онд газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил өмнөх оноос бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар ашигласан зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй. Харин төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх онуудаас тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна.

Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл 2 жил дараалан ашиглаагүй 3836 /37%/, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан 183 /2%/, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан 962 /9%/, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 5348 /52%/, зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.5/.




Зураг 1.3.5. Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх зөрчил

Зураг 1.3.5-аас харахад 2 жил дараалан ашиглаагүй зөрчил 6.3%-иар өсч, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 41.3%-иар буурсан, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 6.5%-иар нэмэгдэж, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 6.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

#### 1.4. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

2019 онд 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд газар ашиглах, эзэмших, эзэмшиж байгаа газраа өмчлөх, шинээр өмчлөх эрхтэй холбогдон ирүүлсэн өргөдөл хүсэлтийн судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 142044 өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинээр газар эзэмших 40517 /28.52%/, шинээр газар ашиглах 2465 /1.74%/, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 18070 /12.72%/, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 12527 /8.82%/, газар ашиглалтын зориулалт өөрчлөх 1107 /0.8%/, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 6137 /4.32%/, эзэмшил газраа бусдад ашиглуулах 500 /0.35%/, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 2075 /1.46%/, эзэмшиж байгаа газраа өмчлөх 6421 /4.52%/, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 2654 /1.87%/, өмчилсөн газраа барьцаалах 6098 /4.29%/, шинээр газар өмчлөх 33039 /23.26%/, өмчлөх эрхээ шилжүүлэх 7667 5.40%/, газар эзэмших, ашиглах эрхээ хүчингүй болгуулах хүсэлт 2767 /1.95%/-ийг тус тус гаргаж ирүүлсэн байна.




Зураг 1.4.1: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгаа



Тайлант онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 142044 өргөдөл, хүсэлт ирснээс 130067 /91.6%/ өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Харин нийт өргөдөл, хүсэлтээс 11977 /8.4%/ өргөдөл, хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.

2018 оны тайлангийн дүнтэй харьцуулахад шинээр газар эзэмших өргөдөл 9446, шинээр газар ашиглах өргөдөл 1208, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 5149, газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах өргөдөл 2739, эзэмшил газраа бусдад ашиглуулах өргөдөл 416, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах өргөдөл 536, хүчингүй болгуулах хүсэлт 1902-оор тус тус нэмэгдэж, газар ашиглалтын зориулалт өөрчлүүлэх хүсэлт 1902, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт 3249, эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт 6769, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх өргөдөл 2235, өмчилсөн газраа барьцаалах 90103, шинээр газар өмчлөх хүсэлт 18498-аар тус тус буурсан байна.



Зураг 1.4.2: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгааг 2018 онтой харьцуулсан байдал

Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь дараах байдалтай байна. Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргасан;
- Өргөдөл, хүсэлтийн бичиг баримт бүрдүүлэлт дутуу;
- Бичиг баримтын зөрчилтэй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон;
- Хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон, давхардсан;
- Инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон;
- Нисэхийн хориотой бүсэд газар эзэмших хүсэлт гаргасан;
- Үерийн аман дээр газар эзэмших, өмчлөх, ашиглах хүсэлт гаргасан.


### 1.5. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2019 онд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбогдон гарсан маргааны судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 3660 маргаан гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1824 /85%/, газар өмчлөхтэй холбоотой 776 /36%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 905 /42%/, газар ашиглахтай холбоотой 155 /7%/ маргаан тус тус гарсан байна.

Хүснэгт 1.5.1: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал


№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
						Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	4	4	25		1	4	18		3		7	
2	Баянхонгор	75	30	38	2	63	29	16	0	7	5	23	0
3	Баян-Өлгий	91	41	10	32	76	32	9	23	15	9	1	9
4	Булган	47	419	3	7	42	43	2	7	5	363	1	0
5	Говь-Алтай	27	0	38	1	23	0	37	0	4	0	1	1
6	Говьсүмбэр	2	2								2		
7	Дархан-Уул	12	0	0	1	9	0	0	1	3	0	0	0
8	Дорнод	7	12	3	0	4	11	1	0	3	2	1	0
9	Дорноговь	115	2	10	2	101	2	0	1	14	0	10	1
10	Дундговь	47	1	3		47	1	3		14	0	10	1
11	Завхан	696		68						696		68	
12	Орхон	113	0	524	0	113	0	0	0	0	0	388	0
13	Өвөрхангай	4	5	16	0	3	2	16	0	1	3	0	0
14	Өмнөговь	5	59	67	0	2	56	4		3	3	63	
15	Сүхбаатар	103	7	2	1	101	7	1	1	2	0	1	0
16	Сэлэнгэ	109	31	37	83	31	29	28	83	78	2	9	0
17	Төв	80	74	39	2	80	74	36	2			3	
18	Увс	35	26	3	6	0	20	3	5	0	6	1	0
19	Ховд	32	6	0	7	21	5	1	0	11	1	0	7
20	Хөвсгөл	88	2	5	1	70	1	5	1	14	0	3	0
21	Хэнтий	43	25	6	4	42	24	6	3	1	0	0	1
22	Нийслэл	89	30	8	6	33	13	2	2	56	20	4	4
<b>Дүн</b>		<b>1824</b>	<b>776</b>	<b>905</b>	<b>155</b>	<b>862</b>	<b>353</b>	<b>188</b>	<b>129</b>	<b>930</b>	<b>416</b>	<b>594</b>	<b>24</b>

Улсын хэмжээнд гарсан нийт 3660 зөрчил, маргааны 1532 зөрчил, маргааныг шийдвэрлэсэн байна.



Зураг 1.5.1: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал

2019 онд гарсан маргааны тоог 2018 онд гарсан маргааны тоотой харьцуулахад газар эзэмших талаар гарсан маргаан 649, өмчлөх талаарх маргаан 39, газар ашиглалттай холбоотой маргаан 46-аар тус тус нэмэгдсэн, хилийн цэстэй холбоотой маргаан 2532-аар буурсан дүнтэй байна /Зураг 1.5.2/.



Зураг 1.5.2: Газрын маргааны тоог өнгөрсөн онтой харьцуулсан байдал

2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1493 захиргааны хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс газартай холбоотой захиргааны 332 хэрэг буюу нийт захиргааны хэргийн **22.23** хувийг эзэлж байна /Хүснэгт 1.5.2/.

Хүснэгт 1.5.2: Хянан шийдвэрлэгдсэн захиргааны хэргийг төрлөөр харуулсан байдал

Шүүхийн үе шат	2017			2018			2019		
	Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь	Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь	Нийт	Газартай холбоотой маргаан	Эзлэх хувь
Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1609	277	17.21	1010	234	23.1	510	97	19.0
Давж заалдах шатны шүүх	441	178	40.36	560	127	22.6	611	147	24.0
Хяналтын шатны шүүх	532	96	17.41	375	99	26.3	372	88	23.0
<b>НИЙТ</b>	<b>2582</b>	<b>551</b>	<b>21.34</b>	<b>1945</b>	<b>460</b>	<b>23.6</b>	<b>1493</b>	<b>332</b>	<b>22.2</b>

/Мэдээллийн эх сурвалж: shuukh.mn-ээс авсан болно/.

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт бүх шатны шүүхээс болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөлд хариу өгсөн байдлыг дүгнэхэд шинжээчийн дүгнэлт 64 болж өмнөх оноос 17-оор өссөн, тус газрын Кадастрын хэлтсээс шүүхийн байгууллагад 269 удаагийн нотлох баримт, хүргүүлсэн нь өмнөх оноос 25-аар буурсан дүнтэй байна.

2019 онд тус Газрын даргын тушаалаар байгуулагдсан шинжээчийн дүгнэлт болон магадлан хэмжилт хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн 64 шинжээчийн дүгнэлт гаргасан байх бөгөөд үүнийг төрлөөр нь авч үзвэл:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс – 20
- Иргэний хэргийн анхан шатны шүүхээс – 31
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн – 6
- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн – 5
- Сэлэнгэ аймгийн прокурорын газрын хяналтын прокурор -1
- Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс-1
- Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс-1

Дээрх тайлан, мэдээнээс дүгнэхэд газрын маргаан гарах үндсэн шалтгаан нь Газартай холбоотой хууль, тогтоомж, журам, зааврын хэрэгжилт болон түүнд тавих хяналт хангалтгүй байх ба албан тушаалтны санаатай болон санаандгүй үйлдэл, шийдвэр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн болон бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтын газарт үйл ажиллагаа явуулах, эзэмшил газраасаа хэтрүүлэн хашаа, байшин барих, хугацаандаа гэрээ сунгуулах хүсэлт гаргаагүй, тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар кадастрын зургийн хэмжилт, зураглалын ажлыг хийлгээгүй зэрэг шалтгааны улмаас газрын маргаан гарч байна.

## 1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасан ба газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан билээ. Мөн “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8-д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”-д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасан байдаг.

Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамж болон Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр барьцааны бүртгэлийг хийж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын Газрын даамал газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэж, жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.


Тухайн бүртгэлээс харахад 2019 онд улсын хэмжээнд 4535 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 45948 улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба нийт 50483 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол Улсын нийт нэгж талбарын 4.59 хувийг барьцаанд нэмж бүртгэсэн байна.

2019 онд газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдлыг улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.6.1, зураг 1.6.1-д үзүүлэв.

*Хүснэгт 1.6.1: Газар эзэмших эрх болон өмчийн газраа шинээр барьцаалсан байдал*

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	914	59	855
2	Баян-Өлгий	1463	261	1202
3	Баянхонгор	1777	89	1688
4	Булган	514	109	405
5	Говь-Алтай	734	202	532
6	Говьсүмбэр	925	88	837
7	Дархан-Уул	2296	272	2024
8	Дорнод	803	49	754
9	Дорноговь	1002	491	511
10	Дундговь	672	84	588
11	Завхан	875	109	766
12	Орхон	2988	211	2777

13	Өвөрхангай	2742	327	2415
14	Өмнөговь	1557	96	1461
15	Увс	1524	272	1252
16	Сүхбаатар	876	91	785
17	Сэлэнгэ	2568	475	2093
18	Төв	1645	99	1546
19	Ховд	1648	238	1410
20	Хөвсгөл	1991	305	1686
21	Хэнтий	1340	114	1226
22	Нийслэл	19629	494	19135
ДҮН		50483	4535	45948



Зураг 1.6.1: Барьцааны бүртгэл /аймгуудаар/

Тайлант онд бүртгүүлсэн газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлаас харахад нийт барьцаанд байгаа газрын 44 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газар байна.

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай буюу төмс, хүнсний ногоо тариалан, жимс, жимсгэний усалгаагүй тариалан, үр тарианы усалгаагүй тариалан, өвөлжөө, хаваржааны гэх мэт газрын банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсныг зураг 1.6.2-д үзүүлэв.




Зураг 1.6.2: Газрын зориулалт ба төрөл

2019 онд улсын хэмжээнд эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба дээрх бүртгэлийг улсын хэмжээнд нэгтгэн сүүлийн 5 жилийн мэдээтэй харьцуулав /Хүснэгт 1.6.2/.

*Хүснэгт 1.6.2: 2019 онд улсын хэмжээнд шинээр эзэмших эрх банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал*

д/д	Аймаг, нийслэл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Архангай	298	104	122	153	178	59
2	Баян-Өлгий	533	934	31	107	317	261
3	Баянхонгор	1040	707	433	524	269	89
4	Булган	231	168	131	160	152	109
5	Говь-Алтай	386	605	449	561	575	202
6	Говьсүмбэр	61	65	103	151	85	88
7	Дархан-Уул	1283	423	189	409	328	272
8	Дорнод	102	63	297	74	87	49
9	Дорноговь	352	93	35	365	405	491
10	Дундговь	57	50	73	161	129	84
11	Завхан	114	358	0	391	91	109
12	Орхон	136	42	744	130	179	211
13	Өвөрхангай	317	323	127	313	365	327
14	Өмнөговь	185	313	58	91	60	96
15	Увс	970	966	130	859	458	272
16	Сүхбаатар	488	156	156	82	119	91
17	Сэлэнгэ	882	1226	8	361	704	475
18	Төв	524	295	199	67	72	99
19	Ховд	393	449	392	380	356	238
20	Хөвсгөл	615	499	343	320	285	305
21	Хэнтий	156	141	56	173	76	114
22	Нийслэл	913	828	4521	5152	6331	494
<b>Нийт</b>		<b>10036</b>	<b>8808</b>	<b>8597</b>	<b>10984</b>	<b>11621</b>	<b>4535</b>

2019 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлаас харахад 82 хувийг банкинд үлдсэн 12 хувийг банк бус санхүүгийн байгууллага, хоршоо болон иргэн, аж ахуй нэгж байгууллагад барьцаалсан байна. Үүнээс хамгийн их хувь буюу 44 хувийг Хаан банкинд, 13 хувийг Хас банкинд, 13 хувийг Төрийн банкинд, 5 хувийг Голомт банкинд, 3 хувийг Худалдаа хөгжлийн банкинд, 4 хувийг бусад банкинд барьцаалсан байна /Зураг 1.6.3/.



Зураг 1.6.3: Газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан жилийн хувьд дунджаар 1.32 жил байна.

### 1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газрын үнэд байршил, зориулалт, орчин нөхцөл, инженерийн шугам сүлжээ, бичиг баримтын бүрэн эсэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөхөөс гадна барилга барих тусгай зөвшөөрөл буюу техникийн нөхцөл, Газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, төр засгийн бодлого шийдвэрээс ихээхэн хамаардаг.

Мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхдог бөгөөд газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудыг судлан зах зээлийн бүтэц, оролцогч талуудын оролцоо, үл хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж, дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зорилгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, сумдын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж байна.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байгаа бөгөөд газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас, түрээслэгч, түрээсүүлэгч болон бусад эх сурвалжаас бүрдүүлж байна.



2019 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 20214 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд байгаа бөгөөд үүнээс тайлант онд 3918 үнийн мэдээг нэмж бүртгэсэн. Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 2716, худалдаа үйлчилгээний зориулалттай 645, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 443, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 37 үнийн мэдээ тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.7.1: Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байдал

№	Аймаг/ нийслэл	Нийт үнийн мэдээ	Үүнээс							
			Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
				Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		
1	Нийслэл	365	294	109	185	52	31	21	0	19
2	Архангай	86	29	23	6	33	7	1	24	0
3	Баян-Өлгий	76	32	9	23	30	19	1	11	1
4	Баянхонгор	82	24	4	20	50	0	1	3	1
5	Булган	84	40	27	13	22	3	1	16	1
6	Говь-Алтай	77	46	15	31	16	11	1	10	1
7	Говьсүмбэр	29	4	1	3	18	6	1	1	1
8	Дархан-Уул	116	104	64	40	9	6	1	2	1
9	Дорноговь	352	234	106	128	87	8	1	15	1
10	Дорнод	265	232	42	190	23	1	1	7	1
11	Дундговь	111	61	3	58	24	9	1	25	1
12	Завхан	43	18	7	11	21	16	1	1	0
13	Орхон	219	201	49	152	11	7	1	0	1
14	Өвөрхангай	124	96	38	58	12	4	1	13	1
15	Өмнөговь	117	98	10	88	14	1	1	1	1
16	Сэлэнгэ	233	66	25	41	19	9	1	138	1
17	Сүхбаатар	131	114	40	74	14	9	1	0	1
18	Төв	703	587	10	577	46	4	1	66	1
19	Увс	80	36	12	24	25	13	1	19	0
20	Ховд	169	159	38	121	4	3	1	1	1
21	Хэнтий	345	168	41	127	92	17	1	78	1
22	Хөвсгөл	111	73	19	54	23	1	1	12	1
<b>Нийт дүн</b>		<b>3918</b>	<b>2716</b>	<b>692</b>	<b>2024</b>	<b>645</b>	<b>185</b>	<b>42</b>	<b>443</b>	<b>37</b>

Тайланд хугацаанд цуглуулсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээний 71 хувийг гэр бүлийн хэрэгцээний, 17 хувийг худалдаа үйлчилгээний, 11 хувийг хөдөө аж ахуйн, 1 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ тус тус эзэлж байна.




Зураг 1.7.1: Газрын зах зээлийн үнийн мэдээний зэлэх хувь.

Нийт цуглуулсан үнийн мэдээний хувьд 2886 буюу 73.6 хувь нь шууд худалдагдсан, 839 буюу 21.4 хувь нь дуудлага худалдаагаар худалдсан, үлдсэн 5.0 хувийг үнэлэгдсэн, түрээсийн, худалдахаар санал болгож буй үнэ тус тус эзэлж байна.



Зураг 1.7.2: Газрын зах зээлийн үнийн мэдээний төрөл.

Үнийн мэдээний эх сурвалжийн хувьд газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас 43.8 хувийг, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас 43.4 хувийг, түрээслэгч, түрээслүүлэгч болон бусад эх сурвалжаас 12.8 хувийг бүрдүүлсэн байна.



Зураг 1.7.3: Газрын зах зээлийн үнийн мэдээний эх сурвалж, эрхийн төрөл.


Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг эрхийн төрлөөр нь ангилахад 1727 өмчилсөн газрын, 2180 эзэмшил газрын, 11 ашиглаг буй газрын үнийн мэдээ тус тус бүртгэгдсэн байна.

*Хүснэгт 1.7.2: 1 метр газрын зах зээлийн дундаж үнэ.*

Аймаг/нийслэл	1 м.кв газрын дундаж үнэ							Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
	Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс				
		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй			
Нийслэл	8900	30000	8200	53600	56000	22000		18500	
Архангай	10200	15000	5700	10000	38000	4700	190		
Баян-Өлгий	5400	9500	2600	28000	45000	9200	150	2600	
Баянхонгор	8900	17000	5600	16000	-	3500	150	5200	
Булган	6800	8400	3200	21000	16000	9900	350	6200	
Говь-Алтай	8000	15400	6900	20000	22000	8600	450	5300	
Говьсүмбэр	4300	5700	2800	28000	15000	4700	200	5600	
Дархан-Уул	6300	7500	3800	25000	36000	21000	2000	13600	
Дорноговь	8800	22000	6500	17000	32000	8900	180	2500	
Дорнод	8200	22000	4700	18000	16000	5800	170	6400	
Дундговь	7400	16600	6000	12000	26000	5600	750	2800	
Завхан	7300	16900	6500	16000	18000	5000	160		
Орхон	8800	19300	5700	30000	27000	21000		16000	
Өвөрхангай	7300	12000	3800	12500	16000	5500	170	1900	
Өмнөговь	8100	23100	7100	12300	13000	9000	150	1900	
Сэлэнгэ	8900	11500	3700	19400	21000	8700	200	13000	
Сүхбаатар	10800	23300	5100	22200	26000	9000	840	2100	
Төв	4400	11500	4000	12600	17000	6600	780	2800	
Увс	4800	14200	6400	17500	20000	3000	1400		
Ховд	5900	11500	4600	21500	27000	5500	190	3200	
Хэнтий	7100	18100	3000	19000	15000	6300	270	1400	
Хөвсгөл	6600	9500	2300	18800	15000	2800	170	1900	
<b>Дундаж</b>	<b>7418</b>	<b>15455</b>	<b>4918</b>	<b>20473</b>	<b>24619</b>	<b>8468</b>	<b>446</b>	<b>5942</b>	

*Гэр бүлийн хэрэгцээний газар:*

Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн гэр бүлийн хэрэгцээний газрын 2716 үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд уг мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй байгаа тул газрын үнийг улсын хэмжээнд дундажлах боломжгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцож гаргасан.



Зураг 1.7.4: Гэр бүлийн хэрэгцээний 1 метр квадрат газрын дундаж үнэ


Тайлант хугацаанд гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл Улаанбаатар хотод хамгийн өндөр бөгөөд байршлаасаа хамаарч харилцан адилгүй байна. Нийслэл Улаанбаатар хотын гэр бүлийн хэрэгцээний 294 газрын зах зээлийн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хөрөнгө оруулалт хийгдээгүй 1 метр квадрат газрын дундаж үнэ 8200 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн 1 метр квадрат газрын дундаж үнэ 30000 төгрөг байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотод нэг айлын 0.07 га газрын дундаж үнэ хөрөнгө оруулалт хийгдээгүй бол 5,740,000 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн бол 21,000,000 төгрөгөөр эдийн засгийн эргэлтэнд орж байна.

Гэр хорооллын газар нь Сүхбаатар, Баянгол дүүрэг болон хотын төвд ойр байх тусам үнэтэй, харин Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт хотын төвөөс холдох тусам үнэ багатай байна.

Мөн аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Дорнод аймагт 20,000-25,000 төгрөг, Орхон, Хэнтий, Баянхонгор, Завхан, Дундговь, Говь-Алтай, Архангай, Увс, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Ховд аймагт 10,000-19,000 төгрөг бусад аймагт 5,000-9,999 төгрөг байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар:

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 418 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.




Зураг 1.7.5: Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ

Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотын хувьд 53600 төгрөг, Орхон, Дархан-Уул, Баян-Өлгий, Говьсүмбэр, Сүхбаатар, Ховд, Булган, Говь-Алтай аймагт 20,000-30,000 төгрөг, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл, Дорнод, Увс, Дорноговь, Баянхонгор, Завхан аймагт 15,000-19,900 төгрөг бусад аймагт 10,000-14,999 төгрөгийн хооронд байна.

ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /Төмс, хүнсний ногоо тариалан, Жимс, жимсгэний усалгаагүй тариалан, Үр тарианы усалгаагүй тариалан, Өвөлжөө, хаваржааны гэх мэт/ газрын зах зээлийн үнийн 443 мэдээ цуглуулсан байна.




Зураг 1.7.6: Хөдөө аж ахуйн 1 метр квадрат газрын газрын дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Дархан-Уул аймагт хамгийн өндөр буюу 2000 төгрөг, Увс аймагт 1400 төгрөг, бусад аймагт 150-840 төгрөгийн хооронд байна. Үүнээс хамгийн бага нь буюу Баян-Өлгий, Баянхонгор, Өмнөговь аймагт хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ 150 төгрөг байна.

Нийслэл хот, Орхон аймгийн хувьд тайлант хугацаанд хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнэ бүртгэгдээгүй байна.

### Үйлдвэрийн газар

Тайлант онд Улсын хэмжээнд үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн 37 мэдээ цуглуулсан үүнээс хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж 18500 төгрөг байна. Харин бусад аймгуудын хувь 1400-16000 төгрөгийн хооронд байна.




Зураг 1.7.7: Үйлдвэр, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ.

2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт **1098697** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгдсэн ба үүнээс **93550** нь буюу 8.51 хувь нь газрын зах зээлийн эргэлтэнд орсон байна. Энэ өмнөх оны мэдээтэй харьцуулахад өссөн дүнтэй гарч байна.

Хүснэгт 1.7.3: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс		Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан		Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлэглэсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2014 он	14742	5521	9221	44025	8341	4982	30702
2015 он	14684	5876	8808	41521	7011	4406	30104
2016 он	23949	10848	13101	42105	7284	3525	31296
2017 он	24344	10984	13360	52402	9117	3876	39409
2018 он	23855	11964	11621	104954	12036	4007	88911
2019 он	31089	17398	13691	62461	12902	3611	45948



Зураг 1.7.8: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

2019 онд 177'193.15 га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн 0.11 хувь нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 1.5 их наяд төгрөг болж нэмэгдсэн судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар Монгол улсын ДНБ 27.4 их наяд төгрөг<sup>1</sup> ба үүнийг газрын санхүүгийн эргэлтийн хэмжээтэй харьцуулахад ДНБ-ний 5.47%-ийг эзэлж газрын үр өгөөж нэмэгдэж байгаа дүн гарч байна.

Иргэн, хуулийн этгээд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэглээнд нэвтрүүлсэн Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д нэвтэрч Газрын кадастрын мэдээллийн сангаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа сонгон бусдад худалдах, түрээслэх зар мэдээллээ үнэ, төлбөргүйгээр байршуулж бусдад арилжаалах боломжтой болсон.

Газар худалдан авах, хөрөнгө оруулалт хийх гэж буй иргэн, хуулийн этгээд тус системээс Газрын кадастр, Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Газрын төлөв байдал, Инженер-геологи, Гео-экологийн талаарх газартай холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээллийг баталгаатай эх үүсвэрээс авч газарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлсэн.

<sup>1</sup> [https://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L05](https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L05)



### 1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

2019 онд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг дараах тогтоол, журам аргачлалуудын дагуу улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”.

#### Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа

2019 онд улсын хэмжээнд 1801 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 676 дуудлага худалдаа хүчинтэй болж, 9598.26 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 622-оор, эзэмшүүлсэн газрын хэмжээ 1899.42 га-гаар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 1.8.1/.


Хүснэгт 1.8.1: 2019 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Талбай /м2/		Төсөвт орсон орлого /мян.төг/	
		2018 он	2019 он	2018 он	2019 он	2018 он	2019 он
1	Архангай	84	137	17155197	21520868	288814.2	558051.0
2	Баян-Өлгий	4	34	12000	239839	30700.0	85616.0
3	Баянхонгор	54	80	49624	441708	281279.1	918837.0
4	Булган	40	83	400469	2147659	51141.9	197323.0
5	Говь-Алтай	24	42	19822	154471	35051.1	25298.0
6	Говьсүмбэр	17	24	758500	1715100	318175.9	1387943.0
7	Дархан-Уул	41	22	210800	46162	15816.4	115568.0
8	Дорноговь	169	155	1654738	26994896	2985038.9	3850425.0
9	Дорнод	53	76	4855692	1597764	461605.6	437905.0
10	Дундговь	13	60	14100	88080	2662.0	47138.0
11	Завхан	10	1	34095	1800	2044.6	3465.0

12	Орхон	8	10	60174	26190	114500.0	190958.0
13	Өвөрхангай	81	69	843000	561196	480009.0	104530.0
14	Өмнөговь	34	32	187300	313200	449446.0	99045.0
15	Сүхбаатар	18	4	41690	706400	73836.0	92439.0
16	Сэлэнгэ	53	83	217037	6828771	136628.8	175807.0
17	Төв	225	288	35397883	25135747	938694.4	910673.0
18	Увс	33	93	43200	185700	84054.0	38668.0
19	Ховд	9	117	39240	1029772	21607.0	80970.0
20	Хөвсгөл	49	47	3792000	1042600	152255.7	155297.0
21	Хэнтий	125	218	10965000	3705719	422900.5	577011.0
22	Нийслэл	35	126	236900	1498992	1148620.8	167115.0
<b>ДҮН</b>		<b>1179</b>	<b>1801</b>	<b>76988461</b>	<b>95982634</b>	<b>8494881.7</b>	<b>10220074.0</b>

2019 онд Сэлэнгэ, Хэнтий, Дорноговь, Архангай, Ховд аймгууд, нийслэл хамгийн олон буюу 100-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, Орхон, Увс, Завхан аймгууд хамгийн бага буюу 10-аас доош газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна.

2018, 2019 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв. /Зураг 1.8.1/.




Зураг 1.8.1: 2018, 2019 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо

2019 онд нийт 1801 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1144 удаагийн буюу 63.6 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 1011 удаагийн буюу 88.4 хувь нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 133 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 11.6 хувь нь дуудлага худалдааны үнийг “Газар өмчлүүлэх,


эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасан хугацаанд төлөөгүй байна.

Мөн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй тохиолдол 53.0 хувь болж 19.0 хувиар нэмэгдсэн, 1 оролцогч оролцсон тохиолдол 12.0 хувь болж 4.0 хувиар нэмэгдсэн, 2 оролцогч оролцсон тохиолдол 24.0 хувь болж 11 хувиар буурсан, 2-оос дээш оролцогч оролцсон тохиолдол 11.0 хувь болж 12 хувиар буурсан байна. /Зураг 1.8.2/.




Зураг 1.8.2: Дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь

Шинэчлэн батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар журамласны дагуу 2018 онд 19 аймаг, нийслэлийн хэмжээнд дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж байсан бол 2019 онд улсын хэмжээнд дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. /Зураг 1.8.3/



Зураг 1.8.3: 2018 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдаа

2019 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт **10 тэрбум 220 сая 74 мянган** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Дорноговь аймгаас 37.7 хувь буюу 3 тэрбум 850 сая төгрөг, Говьсүмбэр аймгаас 13.6 хувь буюу 1 тэрбум 388 сая төгрөг, Баянхонгор аймгаас 9.0 хувь буюу 919 сая төгрөг, Төв аймгаас 8.9 хувь буюу 911 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна /Зураг 1.8.4/.



Зураг 1.8.4: 2018-2019 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /мян.төг/

2018 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт 8.5 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дүн 2019 онд 83 хувиар нэмэгдэж 10.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд сүүлийн 10 жилийн байдлаар дуудлага худалдааны орлого 10 дахин нэмэгдсэн байна. /Зураг 1.8.5/.



Зураг 1.8.5: 2018-2019 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /сая.төг/

### Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт


2019 онд улсын хэмжээнд 24 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 16 нь хүчинтэй болж 334.2 га газрыг

эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо, эзэмшүүлсэн газрын хэмжээ тус тус 2 дахин буурсан байна /Хүснэгт 1.8.2/.

Хүснэгт 1.8.2: 2019 оны газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын мэдээ


№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ /м2/	
		2018 он	2019 он	2018 он	2019 он
1	Архангай	3	1	211500	150000
2	Баян-Өлгий				
3	Баянхонгор	4	3	20971	101255
4	Булган	4	1	911400	1450000
5	Говь-Алтай	11		52593	
6	Говьсүмбэр	2	3	550000	90000
7	Дархан-Уул				
8	Дорноговь	1		427700	
9	Дорнод				
10	Дундговь		1		6500
11	Завхан	1	2	1400	1158
12	Орхон				
13	Өвөрхангай		3		100900
14	Өмнөговь				
15	Сүхбаатар				
16	Сэлэнгэ				
17	Төв	3	3	6200	96200
18	Увс	10	3	261900	30000
19	Ховд	1	2	1750	16000
20	Хөвсгөл				
21	Хэнтий	8	2	1008000	1300000
22	Нийслэл	1		150000	
<b>ДҮН</b>		<b>49</b>	<b>24</b>	<b>3603414</b>	<b>3342013</b>

2018, 2019 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав /Зураг 1.8.6/.



Зураг 1.8.6: 2018-2019 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо

2019 онд 24 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 3 удаагийн буюу 44.9 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ. /Зураг 1.8.7/.



Зураг 1.8.7: Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн эзлэх хувь

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Газрын тухай хуулийн 33.5.-д “Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно” гэж нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2018 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн тул тайлант онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт өмнөх оныхоос буурсан байна.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.

### 1.9. КАДАСТРЫН ХЭМЖИЛТ, ЗУРАГЛАЛЫН ТАЙЛАН

Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд 2018 онд 763057 нэгж талбар улсын бүртгэлд бүртгэгдсэн ба 2019 оны сүүлийн байдлаар 872112 нэгж талбар болж 109055 нэгж талбараар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.9.1: Өмнөх оны өөрчлөлттэй харьцуулсан байдал

Д/д	Кадастрын зургийн өөрчлөлт	2018 он	2019 он	Зөрүү
1	Кадастрын зурагт орсон хуучин байсан нэгж талбар	763057	872112	109055
2	Шинээр нэмэгдсэн нэгж талбар	95291	79156	-16135
3	Шинээр орсон барилга	14627	11605	-3022
4	Нийт барилга	440708	491078	50370
5	Нийт цэгийн тоо	9051	10160	1109
6	Өмнөх онд бүртгэгдсэн цэг, тэмдэгтийн тоо	9169	9051	-118
7	Устсан цэгийн тоо	118	812	694

Тайлант онд 3549 нэгж талбарыг хувааж, 734 нэгж талбарыг нэгтгэж, 5071 нэгж талбарын талбайн хэмжээ өөрчлөгдөж, 79156 нэгж талбар болон 11605 барилга нэмэгдэж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн байна.



Зураг.1.9.1: Тайлант онд Газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт орсон байдал

## 1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1.10.1. Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт


*Хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилт*

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хот, тосгон бусад суурины ангиллын газарт нийт **61127** байршил бүхий **96837** га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт **26830** байршилд **21681** га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 1.10.1.1: Хот, тосгон бусад суурины ангиллын газар дахь газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*


№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Байршлын тоо	Газрын хэмжээ	Байршлын тоо
1	Архангай	609.25	2360	240.75	844
2	Баян-Өлгий	11183.71	5773	132.68	1211
3	Баянхонгор	631.33	2585	74.51	411
4	Булган	805.37	1817	628.49	860
5	Говь-Алтай	786.11	1462	265.517	997
6	Говь-Сүмбэр	387.72	360	395.31	109
7	Дархан-Уул	894.27	861	619.51	352
8	Дорноговь	10789.21	737	5708.3	420
9	Дорнод	7532.17	3523	814.511	1794
10	Дундговь	30933.29	3140	1256.63	545
11	Завхан	689.019	1027	170.47	812
12	Орхон	101.28	53	91.55	65
13	Өвөрхангай	1172.78	3666	508.24	1202

14	Өмнөговь	7003.71	6457	2116.60	3982
15	Сүхбаатар	9528.89	1112	1622.51	298
16	Сэлэнгэ	4222	8404	1452.08	2469
17	Төв	4000.73	4739	2620.78	4147
18	Увс	377.74	1307	197.94	583
19	Ховд	2656.44	254	1253.57	237
20	Хөвсгөл	616.22	2725	276.82	1424
21	Хэнтий	948.14	1826	518.90	892
22	Улаанбаатар	941.30	6800	699.97	3101
	<b>Нийт дүн</b>	<b>96837.31</b>	<b>61127</b>	<b>21681.20</b>	<b>26830</b>



Зураг 1.10.1.1: Хот тосгон, бусад суурин газрын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг байршлын тоогоор нь харьцуулсан байдал





Зураг 1.10.1.2: Хот тосгон, бусад суурин газрын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг талбайн хэмжээгээр харьцуулсан байдал /га-гаар/

Дээрх зургаас харахад Дундговь аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уул уурхайн зориулалтаар ашиглуулахаар нийт 30571.11 га газрыг төлөвлөсөн боловч 2019 оны жилийн эцсийн байдлаар 1125.87 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулсан, мөн Баян-Өлгий аймгийн хэмжээнд жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал, мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэхээр 10020.7 га газрыг төлөвлөсөн боловч 2019 оны жилийн эцсийн байдлаар 23.00 га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тус тус эзэмшүүлсэн нь Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тооцоо судалгаатай, үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна.

2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хот, тосгон, бусад суурины ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Ховд аймаг 93.31 хувь, Төв аймаг 87.51 хувь, Завхан аймаг 79.07 хувь, Говь-Алтай аймаг 68.19 хувьтай тус тус хэрэгжсэн байна. Харин Архангай аймаг 35.76 хувь, Баян-Өлгий аймаг 20.98 хувь, Баянхонгор аймаг 15.90 хувь, Булган аймаг 47.33 хувь, Говьсүмбэр 30.28 хувь, Дархан-Уул аймаг 40.88 хувь, Дорноговь аймаг 56.99 хувь, Дорнод аймаг 50.92 хувь, Дундговь аймаг 17.36 хувь, Өвөрхангай аймаг 32.79 хувь, Өмнөговь аймаг 61.67 хувь, Сүхбаатар аймаг 26.8 хувь, Сэлэнгэ аймаг 29.38 хувь, Увс аймаг 44.61 хувь, Хөвсгөл аймаг 52.26 хувь, Хэнтий аймаг 48.85 хувь, Улаанбаатар хот 45.77 хувьтай тус тус хэрэгжсэн байна.


Орхон аймгийн Баян-Өндөр сумын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэхээр тусгаагүй боловч жилийн эцсийн байдлаар 7 байршилд 2.08 га газрыг эзэмшүүлсэн байна. Мөн нийтийн эдэлбэрийн газарт ашиглуулахаар төлөвлөгөөнд тусгаагүй боловч 1

байршилд 5 га газарт газар ашиглуулах захирамж гаргасан байгаа нь төлөвлөөгүй газарт газар олголт явуулж хууль зөрчсөн үйлдэл болсон байна.

Нийт хот тосгон бусад суурины газрын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө **44 хувьтай** хангалтгүй хэрэгжсэн байна /Хүснэгт 1.10.1.2/

*Хүснэгт 1.10.1.2: 2018, 2019 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувийг харьцуулсан байдал*

Д/д	Аймгийн нэр	2018 %/	2019 %/
1	Архангай	60.11	35.76
2	Баян-Өлгий	15.41	20.98
3	Баянхонгор	14.39	15.90
4	Булган	54.71	47.33
5	Говь-Алтай	40.62	68.19
6	Говь-Сүмбэр	93.71	30.28
7	Дархан-Уул	72.82	40.88
8	Дорноговь	76.40	56.99
9	Дорнод	77.97	50.92
10	Дундговь	308.14	17.36
11	Завхан	96.47	79.07
12	Орхон	258.70	122.64
13	Өвөрхангай	36.43	32.79
14	Өмнөговь	63.58	61.67
15	Сүхбаатар	18.53	26.80
16	Сэлэнгэ	61.12	29.38
17	Төв	68.09	87.51
18	Увс	54.84	44.61
19	Ховд	41.88	93.31
20	Хөвсгөл	76.49	52.26
21	Хэнтий	82.28	48.85
	<b>Нийт дүн</b>		<b>43.89</b>




*Зураг 1.10.1.3: 2018-2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн харьцуулалт /хувиар/*

**Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөөний хэрэгжилт**


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **13877** байршил бүхий **3790548** га газрыг төлөвлөснөөс **9495** байршилд **2393163** га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Хүснэгт 1.10.1.3/

*Хүснэгт 1.10.1.3: Хөдөө аж ахуйн ангиллын газар дахь 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөсөн		Хэрэгжсэн	
		Газрын хэмжээ	Байршлын тоо	Газрын хэмжээ	Байршлын тоо
1	Архангай	45010.95	252	44627.92	158
2	Баян-Өлгий	7113.17	1230	10210.48	1070
3	Баянхонгор	366301.29	655	204618.37	265
4	Булган	346898.10	473	334460.40	345
5	Говь-Алтай	276940.36	605	131300.09	369
6	Говь-Сүмбэр	6.33	22	3.33	20
7	Дархан-Уул	52.75	26	46.93	18
8	Дорноговь	196.94	334	181.4	315
9	Дорнод	165936.18	1281	18977	1006
10	Дундговь	249393.70	768	184.60	466
11	Завхан	246244.10	601	95430.29	317
12	Орхон	18232.09	12	17.63	7
13	Өвөрхангай	286886.34	881	271224.55	564
14	Өмнөговь	118.43	282	107.87	242
15	Сүхбаатар	127670.47	223	109948.50	73
16	Сэлэнгэ	407435.62	967	92146.70	545
17	Төв	415839.21	2053	365889.59	1344
18	Увс	507434.75	532	511541.35	364
19	Ховд	5096.80	110	4553.46	73
20	Хөвсгөл	219461.53	1499	167712.86	1392
21	Хэнтий	98279.35	1071	29980.00	542
22	Улаанбаатар	0.00	0	0	0
	<b>Нийт дүн</b>	<b>3790548.46</b>	<b>13877</b>	<b>2393163.32</b>	<b>9495</b>



Зураг 1.10.1.4: Хөдөө аж ахуйн ангиллын газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан арга хэмжээ /байршлын тоогоор/



Зураг 1.10.1.5: Хөдөө аж ахуйн ангиллын газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан арга хэмжээ /талбайн хэмжээгээр, га-гаар/

2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хөдөө, аж ахуйн ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Дорноговь аймаг 94.3 хувь, Хөвсгөл аймаг 92.9 хувь, Говьсүмбэр аймаг 90.9 хувь, Баян-Өлгий аймаг 87.0 хувь, Өмнөговь аймаг 85.8 хувь, Дорнод аймаг 78.5 хувь, Булган аймаг 72.9 хувьтай тус тус хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.


Харин Архангай аймаг 62.7 хувь, Баянхонгор аймаг 40.5 хувь, Говь-Алтай аймаг 61.0 хувь, Дархан-Уул аймаг 69.2 хувь, Дундговь аймаг 60.7 хувь, Завхан аймаг 52.7 хувь, Орхон аймаг 58.3 хувь, Өвөрхангай аймаг 64.0 хувь, Сүхбаатар аймаг 32.7 хувь, Сэлэнгэ аймаг 56.4 хувь, Төв аймаг 65.5 хувь, Увс аймаг 68.4 хувь, Ховд аймаг 66.4 хувь, Хэнтий аймаг 50.6 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Дундговь аймгийн хэмжээнд ХАА-ын газрын зориулалтаар нийт 249393.7 га газрыг төлөвлөсөн ба жилийн эцсийн байдлаар 184.6 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж, хамгаалах арга хэмжээ авсан байна. Үүнээс Зун намрын бэлчээрийг сэлгэх зориулалтаар 249274.0 га газрыг төлөвлөсөн боловч жилийн эцсийн байдлаар хэрэгжээгүй байна. Иймээс Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахдаа эхнээсээ үнэн бодит үндэслэлтэй боловсруулж байх шаардлагатай байна.

Улсын хэмжээнд нийт хөдөө аж ахуйн ангиллын газрын хэрэгжилт **68.4 хувьтай** хэрэгжсэн байна. /Хүснэгт 1.10.1.4/

Хүснэгт 1.10.1.4: 2018, 2019 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ХАА-ын ангиллын газрын хэрэгжилтийн хувийг харьцуулсан байдал

д/д	Аймаг	2018 /%/	2019 /%/
1	Архангай	133.4	62.7
2	Баян-Өлгий	85.1	87.0
3	Баянхонгор	34.2	40.5
4	Булган	59.0	72.9
5	Говь-Алтай	56.8	61.0
6	Говьсүмбэр	-	90.9
7	Дархан-Уул	78.6	69.2
8	Дорноговь	76.2	94.3
9	Дорнод	88.6	78.5
10	Дундговь	77.3	60.7
11	Завхан	61.3	52.7
12	Орхон	83.3	58.3
13	Өвөрхангай	74.1	64.0
14	Өмнөговь	70.1	85.8
15	Сүхбаатар	16.8	32.7
16	Сэлэнгэ	-	56.4
17	Төв	98.9	65.5
18	Увс	83.8	68.4
19	Ховд	42.0	66.4
20	Хөвсгөл	115.2	92.9
21	Хэнтий	50.8	50.6
<b>Нийт</b>			<b>68.4</b>



Зураг 1.10.1.6: Хөдөө аж ахуйн газрын 2018-2019 оны хэрэгжилтийн харьцуулалт /хувиар/

### Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газарт нийт **405** байршил бүхий **1631977** га газрыг төлөвлөснөөс **305** байршилд **1687859** га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:


Сүхбаатар аймаг 100 хувь, Орхон аймаг 100 хувь, Төв аймаг 95.45 хувь, Увс аймаг 94.95 хувь, Хэнтий аймаг 92.86 хувь, Өвөрхангай аймаг 88.89 хувь, Өмнөговь аймаг 87.5 хувь, Сэлэнгэ аймаг 81.48 хувьтай тус тус хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Харин Булган аймаг 66.66 хувь, Баянхонгор аймаг 57.89 хувь, Говь-Алтай аймаг 50 хувь, Дундговь аймаг 36.36 хувь, Дархан-Уул аймаг 19.05 хувь, Завхан аймаг 5.41 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна. /Хүснэгт 5/

Увс аймгийн хэмжээнд 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Улсын тусгай хамгаалалтад авахаар нийт 185508.3 га газрыг төлөвлөсөн боловч жилийн эцсийн байдлаар 391073.3 га газрыг улсын тусгай хамгаалалтад авсан байна. Үүнд Бөхмөрөн, Зүүнхангай, Өмнөговь, Түргэн, Ховд сумдын нутаг дэвсгэрт газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүйгээр 205565.0 га газрыг улсын тусгай хамгаалалтад авсан байна.

Хүснэгт 1.10.1.5: Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

№	Аймаг, нийслэл	Төлөвлөсөн		Хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь /%/
		Газрын хэмжээ	Байршлын тоо	Газрын хэмжээ	Байршлын тоо	
1	Архангай	51031.40	7	0	0	0
2	Баян-Өлгий	0.00	0	0	0	-
3	Баянхонгор	33411.58	38	4809.89	22	57.89
4	Булган	2261.69	6	2261.6	4	66.66
5	Говь-Алтай	16909.00	2	6909	1	50.0
6	Говь-Сүмбэр	0.00	0	0	0	-
7	Дархан-Уул	464.23	21	453	4	19.05
8	Дорноговь	175402.74	4	181347.87	4	100.0
9	Дорнод	0.00	0	0	0	-
10	Дундговь	4095.25	11	10002.15	4	36.36
11	Завхан	23384.09	37	17600	2	5.405
12	Орхон	0.04	2	0.25	2	100.0
13	Өвөрхангай	3531.37	18	3518.18	16	88.89
14	Өмнөговь	159342.71	32	168113.77	28	87.5
15	Сүхбаатар	1.03	3	1.03	3	100
16	Сэлэнгэ	88710.50	27	16399.62	22	81.48
17	Төв	6556.21	22	6120.71	21	95.45
18	Увс	191354.93	99	396894.51	94	94.95
19	Ховд	314678.30	15	314663	7	46.66
20	Хөвсгөл	553707.55	45	553687.25	57	126.66
21	Хэнтий	7103.00	14	5068	13	92.86
22	Улаанбаатар	32.00	2	10	1	50
<b>Нийт дүн</b>		<b>1631977.62</b>	<b>405.00</b>	<b>1687859.83</b>	<b>305.00</b>	<b>75.31</b>



Зураг 1.10.1.7: Улсын тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт /га-гаар/

**Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах газрын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт**

2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 210 байршилд 8248.48 км зам төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 151 байршилд 4096.85 км замыг ашиглуулсан ба улсын хэмжээнд 72 хувьтай биелсэн байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 1.10.1.6: Зам, шугам сүлжээний газрын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

№	Аймаг, нийслэлийн нэр	Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах /км/				Хэрэгжилтийн хувь /%/
		Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн арга хэмжээ		
		Газрын хэмжээ	Байршлын тоо	Газрын хэмжээ	Байршлын тоо	
1	Архангай	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	-	-	-	-	-
3	Баянхонгор	-	-	-	-	-
4	Булган	3.13	31	2.29	28	90.32
5	Говь-Алтай	27.94	1	27.94	1	100
6	Говь-Сүмбэр	1145	5	163	3	60
7	Дархан-Уул	4448.4	8	2402	3	37.5



8	Дорноговь	1334.58	50	254.25	23	46
9	Дорнод	9.1	4	0	0	0
10	Дундговь	-	-	-	-	-
11	Завхан	-	-	-	-	-
12	Орхон	0	0	0.11	7	
13	Өвөрхангай	61.22	60	58.81	44	73.33
14	Өмнөговь	342	21	346	16	76.19
15	Сүхбаатар	4	2	4	2	100
16	Сэлэнгэ	1.8	2	1.84	2	100
17	Төв	724.3	10	737.9	13	130
18	Увс	77.81	12	45.71	7	58.33
19	Ховд	-	-	-	-	-
20	Хөвсгөл	69.2	4	53	2	50
21	Хэнтий	-	-	-	-	-
22	Улаанбаатар	-	-	-	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>8248.48</b>	<b>210</b>	<b>4096.85</b>	<b>151</b>	<b>71.90</b>

### Газрын нэгдмэл сангийн ангиллын газрын 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газарт нийт **75409** байршил бүхий **551963** га газрыг төлөвлөснөөс **36630** байршилд **4102704** га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна /Хүснэгт 1.10.1.7/.

Мөн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Ховд аймаг 83.64 хувь, Төв аймаг 80.89 хувьтай тус тус хангалттай хэрэгжүүлсэн байна.

Харин Архангай аймаг 38.26 хувь, Баян-Өлгий аймаг 32.57 хувь, Баянхонгор аймаг 21.29 хувь, Булган аймаг 52.65 хувь, Говь-Алтай 66.07 хувь, Говьсүмбэр аймаг 33.77 хувь, Дархан-Уул аймаг 41.19 хувь, Дорноговь аймаг 68.74 хувь, Дорнод аймаг 58.28 хувь, Дундговь аймаг 25.9 хувь, Завхан аймаг 67.93 хувь, Өвөрхангай аймаг 39.04 хувь, Өмнөговь аймаг 62.79 хувь, Сүхбаатар аймаг 27.95 хувь, Сэлэнгэ аймаг 32.3 хувь, Увс аймаг 53.71 хувь, Хөвсгөл аймаг 67.3 хувь, Хэнтий аймаг 49.71 хувь, Улаанбаатар хот 45.77 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Нийт улсын хэмжээнд 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт **49 хувьтай** хэрэгжсэн байна.

*Хүснэгт 1.10.1.7: Зам, шугам сүлжээний газрын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

Д/д	Аймгуудын нэр	2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт /Нийт/				Хэрэгжилтийн хувь /%/
		Төлөвлөсөн		Хэрэгжсэн		
		Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	
1	Архангай	96651.60	2619	44868.67	1002	38.26
2	Баян-Өлгий	18296.88	7003	10343.162	2281	32.57
3	Баянхонгор	400344.20	3278	209502.77	698	21.29
4	Булган	349965.16	2296	337350.493	1209	52.65
5	Говь-Алтай	294635.47	2069	138474.607	1367	66.07

6	Говь-Сүмбэр	394.05	382	398.64	129	33.77
7	Дархан-Уул	1411.25	908	1119.44	374	41.19
8	Дорноговь	186388.89	1075	187237.57	739	68.74
9	Дорнод	173468.35	4804	19791.511	2800	58.28
10	Дундговь	284422.24	3919	11443.38	1015	25.9
11	Завхан	270317.21	1665	113200.764	1131	67.93
12	Орхон	18333.41	67	109.43	74	110.45
13	Өвөрхангай	291590.49	4565	275250.967	1782	39.04
14	Өмнөговь	166464.85	6771	170338.24	4252	62.79
15	Сүхбаатар	137200.39	1338	111572.036	374	27.95
16	Сэлэнгэ	500368.85	9398	109998.399	3036	32.30
17	Төв	426396.15	6814	374631.084	5512	80.89
18	Увс	699167.42	1938	908633.8	1041	53.71
19	Ховд	322431.54	379	320470.03	317	83.64
20	Хөвсгөл	773785.30	4269	721676.932	2873	67.3
21	Хэнтий	106330.50	2911	35566.8962	1447	49.71
22	Улаанбаатар	999.20	6941	725.57	3177	45.77
	<b>Нийт дүн</b>	<b>5519363.39</b>	<b>75409</b>	<b>4102704.39</b>	<b>36630</b>	<b>48.57</b>

**1.10.2. 2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө /улсын хэмжээнд/**


Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **12999931** га газрыг болон хот, тосгон бусад суурины газарт **52940** га газрыг, бусад ангиллын газарт **969181** га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, хамгаалахаар тус тус төлөвлөжээ /Хүснэгт 1.10.2.1./.

*Хүснэгт 1.10.2.1. Улсын хэмжээний 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ*

д/д	Аймаг, нийслэлийн нэр	Хот тосгон, бусад суурины газар	ХАА-н газар	Бусад /Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан/	Нийт
1	Архангай	370.02	7652.91	4.00	8026.93
2	Баян-Өлгий	740.64	7842.28	0.00	8582.92
3	Баянхонгор	4674.88	403580.00	136492.00	544746.88
4	Булган	308.28	336010.48	216.18	336534.94
5	Говь-Алтай	1025.00	8443006.77	50.41	8444082.18
6	Говь-Сүмбэр	812.64	6.33	0.00	818.97
7	Дархан-Уул	312.87	6.42	0.00	319.29
8	Дорноговь	2499.96	74.56	0.00	2574.52
9	Дорнод	3338.61	216872.37	28535.00	248745.97
10	Дундговь	16356.44	5544.11	336758.76	358659.31
11	Завхан	642.44	228155.44	125.04	228922.92
12	Орхон	89.32	18232.09	0.00	18321.41
13	Өвөрхангай	410.18	492963.36	4216.50	497590.04
14	Өмнөговь	5178.70	386.75	1099.40	6664.85
15	Сүхбаатар	653.01	155668.52	6.71	156328.24
16	Сэлэнгэ	3093.91	249693.24	5734.00	258521.15
17	Төв	9803.31	325310.61	38835.08	373949.00
18	Увс	592.89	478764.30	34555.19	513912.38
19	Ховд	444.67	1183078.15	155560.30	1339083.12
20	Хөвсгөл	443.95	275949.86	226868.35	503262.16
21	Хэнтий	490.75	171077.39	14.30	171582.44
22	Улаанбаатар	658.48	55.42	110.00	823.90
	<b>Нийт дүн</b>	<b>52940.96</b>	<b>12999931.35</b>	<b>969181.21</b>	<b>14022053.53</b>

Мөн улсын хэмжээнд 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зам шугам сүлжээний зориулалтаар нийт **13030756 км** газрыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Холбооны шугам 3369 км,
- Авто зам 1283 км,
- Эрчим хүч 13025594 км,
- Ус дулаан дамжуулах хоолой 503 км,
- Ус түгээх, шахах өргөх байгууламж 5 км тус тус төлөвлөсөн байна.



Зураг 1.10.2.1: Газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /хувиар/

### 1.11. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд нийт 1164 Сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 1032, орон нутагт 132 бүртгэгдсэн байна. 2009 оноос хойшхи СӨХ-ны бүртгэгдсэн байдлыг дараах зурагт харуулав /Зураг 1.11.1/.



Зураг 1.11.1. СӨХ-ны тоо

Хүснэгт 1.11.1. СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/

Д/Д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Тоолгоонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Үүнээс					
						Захирамжаар баталгаажигдсан СӨХ-оос газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м2/	Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ны тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ны тоо
1	Архангай	1	1	1	1	1	47900.0	0	0	0	0
2	Баянхонгор	5	5	0	3	3	32925.0	0	0	0	0
3	Баян-Өлгий										
4	Булган	1	1		1	1	32197.9				
5	Говь-Алтай	5	5	0	5	5	51000.0	0	0	0	0
6	Говьсүмбэр	4	2		4	4	131335.0				
7	Дархан-Уул	37	36	32	27	16	562401.0	3	3		32
8	Дорнод	16	16		8	8	160579.0				
9	Дорноговь	20	6	4	6	6	241245.4		3	10	
10	Дундговь	1	1	1	1	1	15700.0				
11	Завхан										
12	Орхон	25	25	25	24	24	855100.0				
13	Өвөрхангай	4	0	0	0	4	33415.0	0	0	0	0
14	Өмнөговь	2	1	1	1	1	9351.7	0	0	0	0
15	Сүхбаатар	1	1	0	1	1	3500.0	0	0	0	0
16	Сэлэнгэ	8	8	8	8	8	337199.0	0	0	0	0
17	Төв										
18	Увс	1	1	0	1	1	49000.0	0	0	0	0
19	Ховд										
20	Хөвсгөл	1		1	1	1	47417.5				
21	Хэнтий										
22	Нийслэл	1032	482	48	1032	794	1322589			40	40
	Нийт	1164	591	121	1124	879	3932856	3	6	50	72

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд нийт **1124** СӨХ-ны **879** нь орчны газраа ашиглах эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, **879** СӨХ-ны орчны **3932856 м.кв** газрыг ашиглуулахаар гэрээ байгуулсан байна.

## 2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

### 2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

2019 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 114736.7 мянган га буюу 73.4 хувь, хот, тосгон бусад суурины газар 906.8 мянган га буюу 0.6 хувь, зам, шугам сүлжээний газар 474.8 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14337.0 мянган га буюу 9.2 хувь, усны сан бүхий газар 685.8 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 25270.5 мянган га буюу 16.2 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тус бүрийн эзлэх хувь

2019 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнг 2018 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 72.5 мянган га, ойн сан бүхий газар 4.5 мянган га, усны сан бүхий газар 0.3 мянган га-гаар тус тус хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 47.1 мянган га, зам, шугам сүлжээний газар 0.5 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 29.7 мянган га-гаар тус тус нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Өөрчлөлт /мян га/
<b>I</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	<b>114809.2</b>	<b>114736.7</b>	<b>-72.5</b>
1	Бэлчээрийн газар	110391.6	110330.6	-61.0
2	Хадлангийн талбай	1709.1	1709.1	0.0
3	Тариалангийн газар	1100.8	1117.2	16.4
4	Атаршсан газар	231.6	216.6	-15.0
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	116.4	103.5	-12.9
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0
<b>II</b>	<b>Хот, тосгон бусад суурины газар</b>	<b>859.7</b>	<b>906.8</b>	<b>47.1</b>
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	79.3	80.1	0.8
8	Нийтийн эдэлбэр газар	322.8	322.1	-0.7

9	Үйлдвэрийн газар	44.9	46.0	1.1
10	Уурхайн газар	333.4	375.8	42.4
11	Гэр хорооллын газар	79.3	82.8	3.5
<b>III</b>	<b>Зам, шугам сүлжээний газар</b>	<b>474.3</b>	<b>474.8</b>	<b>0.5</b>
12	Авто замын газар	335.7	337.8	2.1
13	Төмөр замын газар	31.8	29.8	-2.0
14	Агаарын тээврийн газар	9.2	9.2	0.0
15	Шугам сүлжээний газар	97.6	98.0	0.4
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
<b>IV</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	<b>14341.5</b>	<b>14337.0</b>	<b>-4.5</b>
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12188.6	12187.5	-1.1
18	Ой модыг нь огтолсон газар	143.5	132.9	-10.6
19	Мод үржүүлгийн газар	64.2	65.0	0.8
20	Ой тэлэн ургах нөөц газар	743.3	719.2	-24.1
21	Ойн сангийн бусад газар	1201.9	1232.4	30.5
<b>V</b>	<b>Усны сан бүхий газар</b>	<b>686.1</b>	<b>685.8</b>	<b>-0.3</b>
22	Гол мөрний эзлэх газар	228.5	223.8	-4.7
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	446.3	2.7
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	13.2	0.8
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	2.5	0.9
<b>VI</b>	<b>Улсын тусгай хэрэгцээний газар</b>	<b>25240.8</b>	<b>25270.5</b>	<b>29.7</b>
26	Улсын тусгай хамгаалалттай газар	21140.9	21140.9	0.0
27	Улсын хилийн зурвас газар	3112.0	3112.0	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	34.9	36.1	1.2
31	Аймаг дундын отрын бэлчээр	691.4	691.4	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
35	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	0.0	28.4	28.4
36	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>156411.6</b>	<b>156411.6</b>	

### 2.1.1. Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 114736.7 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 73.4 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 110330.6 мянган га буюу 96.2 хувь, хадлангийн газар 1709.1 мянган га буюу 1.5 хувь, тариалангийн газар 1117.2 мянган га буюу 1.0 хувь, атаршсан газар 216.6 мянган га буюу 0.2 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 130.5 мянган га буюу 0.1 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.7 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Өөрчлөлт /мян га/
1	Хөдөө аж ахуйн газар	114809.2	114744.8	-64.4
1	Бэлчээрийн газар	110391.6	110330.6	-61.0
2	Хадлангийн талбай	1709.1	1709.1	0.0
3	Тариалангийн газар	1100.8	1117.2	16.4
4	Атаршсан газар	231.6	216.6	-15.0
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	116.4	103.5	-12.9
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0

### Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2018 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 61.0 мянган га-аар хасагдсан байна. Тайлант онд уурхайн газар, зам, шугам сүлжээний газар, тариалангийн газар, улсын тусгай хэрэгцээний газарт өөрчлөлт хийж шилжүүлсэн байна.

### Хадлангийн газар

Хадлангийн газар нийтдээ 64 га-гаар нэмэгдсэн байгаа бөгөөд энэ нь Увс аймгийн Бөхмөрөн, Давст, Зүүнговь, Сагил, Тариалан, Түргэн, Цагаанхайрхан, Улаангом зэрэг сумдад бэлчээрийн газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хадлан хадах зориулалтаар газрыг эзэмшүүлсэнтэй холбоотой байна.

### Тариалангийн газар

Тариалангийн газар нь 2018 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 16.4 мянган га-аар нэмэгдсэн байна. Тариалангийн газрын хэмжээнд гарсан өөрчлөлтийг аймаг тус бүрээр дараах хүснэгтээр харуулав /Хүснэгт 2.1.1.2/.

Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /аймгаар/

№	Аймгийн нэр	2018	2019	Өөрчлөлт /га-гаар/
1	Архангай	26457.3	28899.1	2441.8
2	Баянхонгор	2196.3	2194.8	-1.5

3	Баян-Өлгий	2659.9	2662.0	2.1
4	Булган	89374.4	89187.7	-186.7
5	Говь-Алтай	5189.3	5207.4	18.1
6	Говьсүмбэр	3338.0	360.0	-2978.0
7	Дархан-Уул	34205.5	34222.9	17.4
8	Дорноговь	546.2	563.3	17.1
9	Дорнод	101817.7	101821.7	4.0
10	Дундговь	703.3	701.6	-1.7
11	Завхан	10466.2	17406.5	6940.2
12	Орхон	5101.7	5101.7	0.0
13	Өвөрхангай	25365.1	25467.7	102.6
14	Өмнөговь	764.0	740.7	-23.4
15	Сүхбаатар	16727.8	17197.7	469.9
16	Сэлэнгэ	315240.7	315981.8	741.1
17	Төв	258781.2	261391.2	2610.0
18	Увс	70801.6	77391.0	6589.4
19	Ховд	9293.7	9890.1	596.5
20	Хөвсгөл	33931.1	32736.2	-1194.9
21	Хэнтий	80147.9	80257.4	109.5
22	Нийслэл	7715.5	7860.7	145.2
Нийт дүн		1100824.2	1117243.1	16418.9


2018 оны дүнтэй харьцуулахад тариалангийн газар хамгийн их нэмэгдсэн нь Архангай аймагт 2441.8 га, Завхан аймагт 6940.0 га, Төв аймагт 2610.0 га, Увс аймагт 6589.4 га байна. Эдгээр аймгуудын ихэнхэд атаршсан талбайг эргүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шинээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор гарсан өөрчлөлт юм.

Зөвхөн Увс аймгийн хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д заасныг тус тус үндэслэн тус аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8/03 тоот тогтоолоор тариалангийн бүс нутгийг тогтоосонтой холбогдуулан Баруунтуруун, Завхан, Наранбулаг, Өндөрхангай, Сагил, Тариалан, Тэс, Ховд сумдад үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор тариалангийн талбай 6589.4 га-гаар бэлчээрийн газраас нэмэгдсэн байна.

Мөн Говьсүмбэр аймагт тариалангийн газар 2978.0 га-гаар хасагдсан нь тус аймгийн Баянтал сумын нутаг дэвсгэрт “СРСМ” ХХК-д 3000 га газрыг 2015 онд төсөл сонгон шалгаруулалтаар бэлчээрийн газраас малын тэжээл тарих, үнээний ферм байгуулахаар 2015 оны А/44 дүгээр захирамжаар эзэмшүүлсэн байсныг газраа төлбөрөө огт төлөөгүй, газраа зориулалтын дагуу 4 жил огт ашиглаагүй тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон, тус сумын Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/58 дугаар захирамжаар газар эзэмших эрхийг дуусгавар болгосноор тухайн өөрчлөлт гарсан байна.



1990 оноос хойшхи тариалангийн газрын талбайн хэмжээг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.1.2/.



Зураг 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

### Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар


Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар Улсын хэмжээнд нийтдээ 12.9 мянган га-гаар хасагдсан байна.

Ихэнх аймгуудад уг газар бага хэмжээгээр нэмэгдсэн боловч Баян-Өлгий аймагт 12.4 мянган га-гаар хасагдсан байна. Тухайн өөрчлөлтийн шалтгаан нь ГЗБГЗЗГ-аас батлан хүргүүлсэн “Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллого, судалгааг шинэчлэн хийх ажлын удирдамж”-ийн дагуу аймгийн хэмжээний газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн тооллогын ажлыг шинээр зохион байгуулсантай холбоотой гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

#### 2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон бусад суурины газар 906.8 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 80.1 мянган га буюу 8.8 хувийг, нийтийн эдэлбэр газар 322.1 мянган га буюу 35.5 хувийг, үйлдвэрийн газар 46.0 мянган га буюу 5.1 хувийг, уурхайн газар 375.8 мянган га буюу 42.4 хувийг, гэр хорооллын газар 82.8 мянган га буюу 3.5 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот тосгон, бусад суурин газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.2.1. Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Өөрчлөлт /мян га/
II	Хот, тосгон бусад суурины газар	859.7	906.8	47.1
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	79.3	80.1	0.8
2	Нийтийн эдэлбэр газар	322.8	322.1	-0.7
3	Үйлдвэрийн газар	44.9	46.0	1.1
4	Уурхайн газар	333.4	375.8	42.4
5	Гэр хорооллын газар	79.3	82.8	3.5


2019 оны тайлангийн дүнгээр барилга байгууламжийн дэвсгэр газар 0.8 мянган га, гэр хорооллын газар 3.5 мянган га-аар өссөн нь нийслэл, орон нутагт барилга барих зориулалтаар болон Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлж, өмчлүүлж байгаатай холбоотой юм.

Мөн тайлант онд уурхайн газар Баянхонгор аймагт 2748.8, Өвөрхангай аймагт 584.7, Өмнөговь аймагт 1562.1, Сүхбаатар аймагт 236.9, Сэлэнгэ аймагт 174.1 га-гаар нэмэгдсэнтэй байна. Эдгээр аймгуудад уул уурхайн ашиглалтын лицензийг үндэслэн 2019 онд ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад уул уурхайн зориулалтаар эзэмшүүлэх шийдвэр гаргаж, гэрээ байгуулсан байна.

### 2.1.3. Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газар 474.8 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2018 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 0.5 мянган га-аар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 337.8 мянган га буюу 71.1 хувийг, төмөр замын газар 29.8 мянган га буюу 6.3 хувийг, агаарын тээврийн газар 9.2 мянган га буюу 1.9 хувийг, шугам сүлжээний газар 98.0 мянган га буюу 20.6 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.



Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Өөрчлөлт /мян га/
III	Зам, шугам сүлжээний газар	474.3	474.8	0.5
1	Авто замын газар	335.7	337.8	2.1
2	Төмөр замын газар	31.8	29.8	-2.0
3	Агаарын тээврийн газар	9.2	9.2	0.0
4	Шугам сүлжээний газар	97.6	98.0	0.4
4	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

Автозамын газар Хөвсгөл, Төв зэрэг аймагт автозамын газрыг шинээр бүртгэснээр автозамын газар 2.1 мянган га-гаар нэмэгдсэн байна.


Төмөр замын газар улсын хэмжээнд 2.0 мянган га-гаар хасагдсан байгаа нь Өмнөговь аймагт Баян-овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрийг дайрсан төмөр зам барих зориулалтаар олгосон газрыг аймгийн Засаг даргын захирамжаар газар эзэмших эрхийг дуусгавар болгож бэлчээрт шилжүүлсэн байна.

Шугам сүлжээний газар Говь-Алтай, Говьсүмбэр, Өмнөговь, Дорнод, Өмнөговь, Төв аймгууд болон нийслэлд цэвэр, бохир ус дамжуулах хоолой, эрчим хүчний шугамыг шинээр барьж байгуулан бүртгэснээр улсын хэмжээнд 0.4 мянган га-гаар нэмэгдсэн дүнтэй байна.

#### 2.1.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 14337.0 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12187.5 мянган га буюу 85.0 хувийг, ой модыг нь огтолсон газар 132.9 мянган га буюу 0.9 хувийг, мод үржүүлгийн газар 65.0 мянган га буюу 0.5 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 719.2 мянган га буюу 5.0 хувийг, ойн сангийн бусад газар 1232.9 мянган га буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.4.1/.



Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү /мян га/
IV	Ойн сан бүхий газар	14341.5	14337.0	-4.5
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12188.6	12187.5	-1.1
2	Ой модыг нь огтолсон газар	143.5	132.9	-10.6
3	Мод үржүүлгийн газар	64.2	65.0	0.8
4	Ой тэлэн ургах нөөц газар	743.3	719.2	-24.1
5	Ойн сангийн бусад газар	1201.9	1232.4	30.5

2019 онд мод үржүүлгийн газар 0.8 мянган га-гаар хасагдсан нь Дорнод аймгийн Халхгол суманд мод үржүүлгийн 1000 га газрыг ойн сангийн бусад газарт шилжүүлсэн байна. Мөн тус аймгийн Баян-Уул суманд улс, аймаг, орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 3 мэргэжлийн байгууллага 158.0 га талбайд ойжуулах ажлыг, 173.8 га талбайд мод бэлтгэх ажлыг хийснээр ойн сан бүхий газрын ангилал дотроо шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.


Сэлэнгэ аймагт мөн ойн сан бүхий газрын үндсэн ангилал дотроо шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Ойн сан бүхий газар улсын хэмжээнд 4.5 га-гаар хасагдсан нь Хөвсгөл аймгийн Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын нутаг Тэнгис-Шишгэдийн голын ай сав орчмын 869100 га, Чандмань-Өндөр сумын нутаг 57323 га газар б 90399 га болж газар нутгийг шинээр Байгалийн цогцолбор газрын ангилалд, Улаан-Уул сумын нутаг Улаан тайгын байгалийн цогцолбор газрын хилийн заагийг Улаан-Уул, Баянзүрх сумдын нутгийн зарим хэсгийг хамруулан 326300 га болгож, Дархан цаазат газрын ангилалд хамруулсныг Улсын тусгай хамгаалалттай газрынтайланд тусгаснаар ойн сан бүхий газар улсын тусгай хэрэгцээний газарт шилжсэнтэй холбогдон гарсан өөрчлөлт юм.

### **2.1.5. Усны сан бүхий газар**

Усны сан бүхий газар 685.8 мянган га буюу нийт газар нутгийн 0.4 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 223.8 мянган га буюу 32.6 хувийг, нуур, цөөрөм 446.3 мянган га буюу 65.1 хувийг, горхи, булаг, шанд 13.2 мянган га буюу 1.9 хувийг, мөнх цас, мөсөн гол 2.5 мянган га буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.5.1/.



Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын эзлэх хувь

Усны сан бүхий газрын хэмжээ нь Завхан, Өмнөговь зэрэг аймгуудад ангилал дотроо өөрчлөгдсөнөөс гадна улсын тусгай хэрэгцээний газарт шилжсэн дүнтэй байна.

Хүснэгт 2.1.5.1: Усны сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Өөрчлөлт /мян га/
V	Усны сан бүхий газар	686.1	685.8	-0.3
1	Гол мөрний эзлэх газар	228.5	223.8	-4.7
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	443.6	446.3	2.7
3	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	13.2	0.8
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.6	2.5	0.9

## 2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/

2019 оны байдлаар Улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 25,270.5 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 16.16 хувийг эзэлж байна.



Зураг 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21140.8 мянган га буюу 83.76 хувийг, улсын хилийн зурвас газар 3111.9 мянган

га буюу 12.33 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.49 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.03 мянган га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 36.13 мянган га буюу 0.14 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.41 мянган га буюу 2.74 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.94 мянган га буюу 0.44 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.47 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2.11 мянган га буюу 0.01 хувийг, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар 28.4 мянган га буюу 0.11 хувийг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар 0.03 мянган га буюу 0.0001 хувийг тус тус эзэлж байна.


Тайланд онд дараах газруудыг улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Үүнд:

- Монгол Улсын Улсын Их Хурлын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 100 дугаар тогтоолоор Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Арабын Нэгдсэн Эмират Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны 0.1449 га газрыг гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрын зориулалтаар;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 155 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд ашиглаж байгаа 400 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор Төв аймгийн Баянчандмань, Борнуур, Жаргалант, Баянцагаан, Зуунмод, Сэргэлэн сум, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Нийслэлийн Сонгинохайрхан, Налайх, Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийт 1165.6 га шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн зориулалтаар;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 337 дугаар тогтоолоор Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 22 га, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт 10 га газрыг тус тус аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 357 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлах “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийг хэрэгжүүлэх 28000 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар.

Дээр дурдсан 2019 онд улсын тусгай хэрэгцээнд авсан газруудтай холбоотой өөрчлөлтийг ГТ-4 тайланд тусгалаа.

Хүснэгт 2.2.1. Улсын тусгай хэрэгцээний газар /га-гаар/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	2018	2019	Зөрүү
VI	<b>Улсын тусгай хэрэгцээний газар</b>	25240899.26	25270497.04	29597.78
1	Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд	21140880.62	21140880.62	0.00
а	<i>Дархан цаазат газар</i>	<i>10919403.00</i>	<i>10919403.00</i>	<i>0.00</i>
б	<i>Байгалийн цогцолборт газар</i>	<i>8097821.00</i>	<i>8097821.00</i>	<i>0.00</i>
в	<i>Байгалийн нөөц газар</i>	<i>2044351.62</i>	<i>2044351.62</i>	<i>0.00</i>
г	<i>Дурсгалт газар</i>	<i>79305.00</i>	<i>79305.00</i>	<i>0.00</i>
2	Улсын хилийн зурвас газар	3111994.94	3111994.94	0.00
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124097.61	124097.61	0.00
4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	33.68	33.82	0.14
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	34960.21	36125.84	1165.63
6	Аймаг дундын отрын бэлчээр	691413.80	691413.80	0.00
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110940.00	110940.00	0.00
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24470.00	24470.00	0.00
9	Эдийн засгийн чөлөөт бүсийн газар	2108.40	2108.40	0.00
10	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	0.00	28400.00	28400.00
11	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	0.00	32.00	32.00



Зураг 1.2.2: Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га/

Энэхүү өөрчлөлтөөр хөдөө аж ахуйн газраас 28417.7 га, хот тосгон, бусад суурины газраас 435.0 га, зам, шугам сүлжээний газраас 19.7 га, усны сан бүхий газраас 725.4 га газар тус тус улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн байна.

Хүснэгт 1.2.2: Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн газрууд /га/


д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Талбайн хэмжээ /га/	
1	Хөдөө аж ахуйн газар	Бэлчээр	27883.7
		Хадлан	497.5
		Атаршсан газар	5.5
		ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	31.1
2	Хот тосгон, бусад суурины газар	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	400.3
		Нийтийн эдэлбэрийн газар	34.7
3	Зам, шугам сүлжээний газар	Авто зам	14.8
		Шугам сүлжээний газар	4.9
4	Усны сан бүхий газар	Мөрөн гол, горхи, булаг, шанд	690.2
		Нуур, цөөрөм, тойром	35.2

Харин тайлант онд Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалттай газрууд болох Говийн их дархан цаазат газрын "Б" хэсэг, Отгонтэнгэрийн дархан цаазат газар, Нөмрөгийн дархан цаазат газар, Монгол дагуурын "Б" хэсгийн дархан цаазат газар, Булган гол-Их



Ононгийн байгалийн цогцолборт газар, Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газар, Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн заагт тус тус өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү өөрчлөлтөөр тогтоосон газрын нэгдмэл сангийн ангиллыг тодохойлоогүйгээс шалтгаалан тайланд тусгах боломжгүй байна.

2019 онд Улсын тусгай хэрэгцээний газрыг Кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулахтай холбоотойгоор Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжид нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийлээ.



Зураг 2.2.3: Улсын тусгай хэрэгцээний газрыг Кадастрын нэгдсэн санд бүртгэх програм хангамж

Энэхүү программыг ашиглан Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам"-ын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авсан газруудыг Кадастрын нэгдсэн системд бүртгэж, Улсын тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ, кадастрын зураг хэвлэж олгох, хувийн хэрэг үүсгэх ажлыг хийлээ. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 378 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд;
- УИХ-ын 2013 оны 53 дугаар тогтоолоор Дотоодын цэргийн 05 дугаар ангийн байнгын байрлалын зорилгоор 6.29 га газрыг, Цагдаагийн ерөнхий газрын Сүүж уул дахь сургалт, дадлагын цогцолбор төвийн зорилгоор 797.74 га газрыг, Дотоодын цэргийн 811 дүгээр ангийн Буудлагын талбайн зорилгоор 924.08 га газрыг, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн Хугацаат цэргийн албан хаагчдын зуны байрны зорилгоор 58.93 га газрыг тус тус нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн байнгын байрлалын зорилгоор 3.13 га газрыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутагт Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар


олгосон газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд;

- Засгийн газрын 2016 оны 154 дүгээр тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах “Олон улсын нисэх онгоцны буудал”-ын зорилгоор үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу 9710 га газрыг Барилга, хот байгуулалтын яаманд;
- Засгийн газрын 2019 оны 357 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын нутаг дэвгэрийг дамнан байрлах “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийг хэрэгжүүлэх 28000 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу Эрчим хүчний яаманд.

2020 онд энэхүү программын ашиглан өмнө нь улсын тусгай хэрэгцээнд авсан газруудын мэдээллийг Кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөөд байна.


### 2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд нийт **7560243.14** га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс **64317.90** га-г өмчилж, **7130754.38** га-г эзэмшиж, **337604.32** га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага **27566.54** га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.




Зураг 2.3.1: 2019 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /хувиар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2018 онтой харьцуулбал **585168.54** га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.




Зураг 2.3.2: Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2018 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар **64317.90** га болж **2100.56** га-аар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж буй газар **7130754.38** га болж **629128.55** га-гаар /Зураг 2.3.4/ тус тус өссөн дүнтэй байна. Харин иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар **337604.32** га болж **46060.57** га-гаар /Зураг 2.3.6/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар **27566,54** га болж **51,33** га-гаар тус тус хасагдсан байна /Зураг 2.3.3-2.3.6/.




Зураг 2.3.3: Өмчлүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.4: Эзэмшүүлсэн газар /га-гаар/




Зураг 2.3.5: Бусдад ашиглуулж буй эзэмшлийн газар /га-гаар/



Зураг 2.3.6: Ашиглуулсан газар /га-гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт **1323635.77** га, хот тосгон, бусад суурины газарт **600125.87** га, зам, шугам сүлжээний газарт **175563.49** га, ойн сан бүхий газарт **347900.92** га, усны сан бүхий газарт **83236.67** га, улсын тусгай хэрэгцээний газарт **5030043.13** га газар өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.



Зураг 2.3.7: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/

Хүснэгт 2.3.1: Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2018 он	2019 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	132.0	135.4	3.4
		эзэмшигч	1322899.1	1290246.9	-32652.2
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7135.5	7138.0	2.5
		ашиглагч	66658.1	25912.8	-40745.3
		нийт	1396824.7	1323433.1	-73391.6

2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	62085.2	63790.8	1705.6
		эзэмшигч	327452.5	328344.2	891.7
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	16731.3	16731.3	0.0
		ашиглагч	195729.8	191199.5	-4530.3
		нийт	601998.8	600065.8	-1933.0
3	Зам, шугам шүлжээний газар	өмчлөгч	0.0	0.07	0.07
		эзэмшигч	148248.6	146246.0	-2002.6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3370.8	3368.2	-2.6
		ашиглагч	26734.3	25949.3	-785.0
		нийт	178353.7	175563.5	-2790.2
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	674502.4	341963.4	-332539.0
		ашиглагч	5937.6	0.0	-5937.6
		нийт	680440.0	341963.4	-338476.6
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	83213.7	83236.7	23.0
		ашиглагч	0.0	0.0	0.0
		нийт	83213.7	83236.7	23.0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	3945309.7	4940717.2	995407.5
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	380.4	329.1	-51.3
		ашиглагч	88605.2	88605.2	0.0
		нийт	4034295.3	5030043.1	995747.8


Тайлбар: Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас баталсан удирдамжийн дагуу “Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллогын ажил”-ыг шинэчлэн зохион байгуулах, зөрчилтэй нэгж талбарын судалгааг гаргах ажлын хүрээнд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумдын Газрын даамлууд хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллого /суурин аргаар/;
- Эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбаруудад газрын харилцаатай холбоотой үүссэн зөрчилтэй нэгж талбаруудын судалгаа гаргах;
- Зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгасан судалгаа
- Хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбаруудын захирамжийг хүчингүй болгох;
- Газрын улсын бүртгэлийн мэдээллийг сүүлийн байдлаар шинэчлэн гаргах;

Үүнтэй холбоотойгоор 21 аймгийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн 2019 оны эрх зүйн байдлын тайланг гаргахдаа дээр дурьдсан газрын улсын бүртгэлийн шинэчилсэн бүртгэлийг ашигласны үр дүнд иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын талбайн хэмжээ өмнөх оны тоон мэдээлэлтэй харьцуулахад багассан үр дүнтэй байгаа бөгөөд дараах аймгуудад их хэмжээний өөрчлөлт орсон байна /Зураг 2.3.8/.

Мөн Дорнод аймгийн хэмжээнд тайлант онд Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 41 дүгээр


тогтоолоор Баяндун суманд Баяндун уул, Баянтүмэн суманд Халх таван уул, Матад суманд Жаран тогооны А, Б тал, Мэнэнгийн цагаан хоолой, Халхгол суманд Нөмрөг, Ташгай таван нуур, Чойбалсан суманд Хөх нуур, Гурванзагал, Дашбалбар суманд Монгол дагуур Б газруудыг дархан цаазат газар 515905.84 га, байгалийн нөөц газар 481621.73 га, нийт 997527.57 га газрыг Улсын тусгай хамгаалалтанд авсан байна.



Зураг 2.3.8: Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын 2019 оны тайланг 2018 оны тайлантай харьцуулсан байдал /эзэмшлийн газар/


#### 2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/

2019 онд улсын хэмжээнд нийт **1098376** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ **6503**-өөр өссөн байна /Зураг 2.4.1/.




Зураг 2.4.1: Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/

Тайлант онд газар өмчлөгч **637501**, эзэмшигч **448990**, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **10687**, газар ашиглагч **1198** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.




Зураг 2.4.2: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын хувь



Газрын эрхийн төрлөөр 2018 оны үзүүлэлттэй харьцуулахад газар өмчлөгчийн тоо **637501** болж, **22047**-оор /Зураг 2.4.3/, газар ашиглагчийн тоо **1198** болж **31**-ээр /Зураг 2.4.6/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо **10687** болж 9354-өөр /Зураг 2.4.5/ тус тус өссөн дүнтэй байна. Харин газар эзэмшигчийн тоо **448990** болж **24929**-өөр /Зураг 2.4.4/ багассан дүнтэй байна.



Зураг 2.4.3: Газар өмчлөгч /тоогоор/




Зураг 2.4.4: Газар эзэмшигч /тоогоор/



Зураг 2.4.5: Бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/

Зураг 2.4.6: Газар ашиглагч /тоогоор/

Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт **177344**, хот тосгон, бусад суурины газарт **912391**, зам, шугам сүлжээний газарт **2754**, ойн сан бүхий газарт **4273**, усны сан бүхий газарт **64**, улсын тусгай хэрэгцээний газарт **1544** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.



Зураг 2.4.7: Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /эзлэх хувь/

Хүснэгт 2.4.1: Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2018	2019	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	88	92	4
		эзэмшигч	195448	177017	-18431
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	1333	186	-1147
		ашиглагч	50	49	-1
		НИЙТ	196919	177344	-19575




2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	615365	637408	22043
		эзэмшигч	270769	264051	-6718
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	186	10077	9891
		ашиглагч	801	855	54
		нийт	887121	912391	25270
3	Зам, шугам шүлжээний газар	өмчлөгч		1	
		эзэмшигч	2461	2457	-4
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	53	30	-23
		ашиглагч	265	266	1
		нийт	2779	2754	-25
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	4017	4266	249
		ашиглагч	30	7	-23
		нийт	4047	4273	226
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	64	64	0
		ашиглагч	0	0	0
		нийт	64	64	0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	1160	1135	-25
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	899	388	-511
		ашиглагч	21	21	0
		нийт	2080	1544	-536

Тайлбар: Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас баталсан удирдамжийн дагуу өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллогын ажлыг шинэчлэн зохион байгуулах, зөрчилтэй нэгж талбарын судалгааг гаргах ажлыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумдын Газрын даамлууд хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллого /суурин аргаар/;
- Эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбаруудад газрын харилцаатай холбоотой үүссэн зөрчилтэй нэгж талбаруудын судалгаа гаргах;
- Зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгасан судалгааг гаргах;
- Хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбаруудын захирамжийг хүчингүй болгох;
- Газрын улсын бүртгэлийн мэдээллийг сүүлийн байдлаар шинэчлэн гаргах.

Үүнтэй холбоотойгоор 21 аймгийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн 2019 оны эрх зүйн байдлын тайланг гаргахдаа дээр дурьдсан газрын улсын бүртгэлийн шинэчилсэн бүртгэлийг ашигласны үр дүнд иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тоо өмнөх оны тоон мэдээлэлтэй харьцуулахад багассан дүнтэй байна.




Зураг 2.4.8: Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын 2019 оны тайланг 2018 оны тайлантай харьцуулсан байдал /эээмшлийн газар/

## 2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

21 аймаг, нийслэлээс ирүүлсэн 2019 оны “Газарт учруулсан хохирлын тайлан”-г Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан ГТ-6 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

2019 онд улсын хэмжээнд нийт 7815714.1 га газарт хохирол учирсан байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 139196.9 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 7.0 сая га, хот тосгон, бусад суурин газрын 49882.8 га, ойн сан бүхий газрын 570824.2 га, усны сан бүхий газрын 1802.2 га газарт тус тус хохирол учирсан бол 23852.6 га газар ухагдаж эвдэрсэн байна /Зураг 2.5.1/



Зураг 2.5.2: Газарт учруулсан хохирлын хэмжээ /аймгуудаар/.


### 2.5.1. Тариалангийн газар

Тариалангийн газрын хохирлын тайланг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон, бусад гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 139196.9 га тариалангийн талбайд хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 1.8 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 32959.1 га талбайгаар өссөн байна.

Тариалангийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө 106'753.9 га (77%), хөрсний үржил шимийн бууралт 27'888.6 га (20%) байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл салхины эвдрэлд орсон 3393.5 га, онц аюултай ургамалд нэрвэгдсэн 384,5 га, усны эвдрэлд орсон 378.5 га, хөрс бохирдсон 26 га гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.1.1/



Зураг 2.5.1.1: Тариалангийн газарт учирсан хохирол, га-аар.


### 2.5.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газарт учирсан хохирлын тайланг талхлагдсан, салхи, усны эвдрэлд орсон, намагжсан, элсний нүүлтэд орсон, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтод өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 7030155.4 га бэлчээрт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 89.9 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 30149.7 га талбайгаар илүү байна.

Бэлчээрийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 68 хувь буюу 4770027.1 га талбай мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд өртсөн байна.

Хохирол учирсан бэлчээрийн газрыг ангилж үзвэл талхлагдсан 1345525.2 га (19%), цөлжсөн 740581.7 га (10%), элсний нүүлтэд орсон 123300.7 га (2%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 42520.4 га (1%), салхи, усны эвдрэлд орсон 5810.9 га, намагжсан 2389.5 га гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.2.1/



Зураг 2.5.2.1: Бэлчээрт учирсан хохирол, га-аар.

2019 оны мэдээгээр Сүхбаатар, Дундговь, Дорнод, Төв аймгийн бэлчээрт хамгийн их хохирол учирсан байна.

### 2.5.3. Хот тосгон, бусад суурин газар


Хот тосгон, бусад суурин газарт учирсан хохирлын тайланг ургамлан бүрхэвчгүй болсон, элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон, бусад гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 49882.8 га хот суурины газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.6 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 28333.5 га талбайгаар илүү байна.

Хот тосгон, бусад суурин газрын бохирдолд нөлөөлсөн гол хүчин зүйл нь хүний үйл ажиллагаанаас шалтгаалан ургамлан бүрхэвчгүй болсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон зэрэг байна.

Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 49 хувь буюу 24487.5 га газрыг ахуйн хог хаягдлаар бохирдуулсан, 43.7 хувь буюу 21840.6 га талбай ургамлан бүрхэвчгүй болж доройтсон байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл бусад 3068.4 га (6.1%), элсний нүүлтэд орсон 384.2 га (0.7%), үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 101.9 га (0.2%) гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.3.1/



Зураг 2.5.3.1: Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, га-аар.

2019 оны мэдээгээр Хөвсгөл, Өвөрхангай, Дорнод аймгуудийн хот, тосгон бусад суурингийн газарт хамгийн их хохирол учирсан байна.


#### 2.5.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрын хохирлын тайланг түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавьжинд идэгдсэн, мод бут, сөөг, загийг устгасан, ашигт малтмалын олборлолтод өртсөн, бусад гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 570824.2 га ойн сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 7.3 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 361507.3 га талбайгаар их байна.

Ойн сан бүхий газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл нь ойн түймэр байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 47.4 хувь буюу 270909.5 га газар ойн түймэрт нэрвэгдсэн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл өвчин хортон шавьжид идэгдсэн 196530.9 га (34.4%), мод бут, сөөг, загийг устгасан 103365.5 га (18.1%) гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.4.1/



Зураг 2.5.4.1: Ойн сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.

2019 оны мэдээгээр Архангай, Хөвсгөл, Хэнтий аймгуудын ойн сан бүхий газарт хамгийн их хохирол учирсан байна.

### 2.5.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрын хохирлын тайланг гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 1'802.2 га усны сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.002 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1626.9 га талбайгаар их байна.

Усны сан бүхий газрын хамгийн их хохирол учирсан талбай бол гадаргын болон гүний усны ойр орчмын газар байгаа бөгөөд нийт хохирол учирсан талбайн 91.7 хувь буюу 1654.2 га байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн 96.0 га (5.3%), бусад 52.0 га (2.8%) гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.5.1/



Зураг 2.5.5.1: Усны сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.

2019 оны мэдээгээр Хөвсгөл, Дархан-Уул, Говь-алтай аймгуудын усны сан бүхий газарт хамгийн их хохирол учирсан байна.


### 2.5.6. Ухагдаж эвдэрсэн газар

Ухагдаж эвдэрсэн газрыг геологийн эрэл хайгуулын ажлаас, ашигт малтмалын олборлолтоос, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас, зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 23852.6 га газар ухагдаж эвдэрсэн нь нийт хохирол учирсан талбайн 0.3 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 5580.6 га талбайгаар илүү байна.

Ашигт малтмалын олборлолтын улмаас хамгийн их талбай ухагдаж эвдэрсэн байна. Өөрөөр хэлбэл ухагдаж эвдэрсэн газрын 97.8 хувь буюу 23329.5 га газар ашигт малтмалын олборлолтод өртсөн байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 223.0 га (0.9%), зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас 186.4 га (0.7%), батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанаас 96.8 га (0.4%), геологийн эрэл хайгуулын ажлаас 17 га (0.07%) гэсэн дараалалтай байна. /Зураг 2.5.6.1/



Зураг 2.5.6.1: Ухагдаж эвдэрсэн газар, га-аар.


2019 оны мэдээгээр Нийслэл, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь аймагт газар хамгийн их ухагдаж эвдэрсэн байна.

## 2.6. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГТ-7/

21 аймаг, нийслэлээс ирүүлсэн 2019 оны “Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан”-г ГТ-7 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

2019 онд улсын хэмжээнд нийт 3245326.2 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна. Үүнийг дотор нь ангилан үзвэл тариалангийн 304427.6

га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 2805650.2 га, хот тосгон, бусад суурин газрын 50797.9 га, ойн сан бүхий газрын 67'897.1 га, усны сан бүхий газрын 4'516.5 га газарт хамгаалах арга хэмжээг авсан бол 12'037.0 га газрыг уурхайн эдэлбэр газарт нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна /Зураг 2.6.1/.



Зураг 2.6.1: Газар хамгаалах арга хэмжээ.

### 2.6.1 Тариалангийн газар

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг олон наст ургамал тарьсан, зурваслан тариалсан, ойн зурвасаар хамгаалагдсан, химийн бордоогоор бордсон, шим ба эрдэс бордоогоор бордсон, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 304427.6 га тариалангийн талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 9.3 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 126946.7 га талбайгаар илүү байна.

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай, шим ба эрдэс бордоогоор бордсон талбай эзэлж байна. /Зураг 2.6.1.1/



Зураг 2.6.1.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан тариалангийн газар, га-аар.




2019 оны мэдээгээр Хөвсгөл, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

### 2.6.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг элсний нүүлтээс хамгаалсан, тордон сайжруулсан, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн, хог хаягдлаас цэвэрлэсэн, даацыг зохицуулсан, ашиглалтаас чөлөөлсөн, сэлгэж ашигласан гэсэн 7 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 2805650.2 га бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 86.4 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 457195.3 га талбайгаар илүү байна.

Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг сэлгэж ашигласан талбай, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай эзэлж байна. /Зураг 2.6.2.1/



Зураг 2.6.2.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бэлчээрийн газар, га-аар.

2019 оны мэдээгээр Төв, Баянхонгор, Увс аймагт бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

### 2.6.3. Хот тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг хөрсжүүлж зүлэгжүүлсэн, мод бут сөөг тарьсан, далан хаалтаар хамгаалсан, нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан, ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн, үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн, элсний нүүлтээс хамгаалсан, химийн болон цацраг идэвхт бодисоос цэвэрлэсэн гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 50797.9 га хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 1.5 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 24250 га-аар илүү байна.

Хот, тосгон, бусад суурины газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг ахуйн хог хаягдлыг цэвэрлэсэн талбай эзэлж байна. /Зураг 2.6.3.1/



Зураг 2.6.3.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан хот тосгон, бусад суурин газар, га-аар.

2019 оны мэдээгээр Хөвсгөл, Дундговь, Өмнөговь аймагт хот тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

#### 2.6.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ойн цэвэрлэгээ хийсэн, өвчин хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан, мод бут сөөг шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 67897.1 га ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 2.0 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 135854.6 га-аар бага байна.

Ойн сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг өвчин, хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан талбай эзэлж байна. /Зураг 2.6.4.1/



Зураг 2.6.4.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан ойн сан бүхий газар, га-аар.


2019 оны мэдээгээр Булган, Увс, Завхан, Хөвсгөл аймагт ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

### 2.6.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан, усны үер, эвдрэлээс хамгалах арга хэмжээ авсан гэсэн 3 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийтдээ 4'516.5 га усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 0.1 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 2'405.7 га-аар илүү байна.

Усны сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан талбай эзэлж байна /Зураг 2.6.5.1/.




Зураг 2.6.5.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан усны сан бүхий газар, га-аар.

2019 оны мэдээгээр Дархан-Уул, Төв, Хөвсгөл аймагт усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.

### 2.6.6. Уурхайн эдэлбэр газар

Уул уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн 12037 га газарт хамгаалалтын арга хэмжээ авснаас 11633.1 га талбайг эргүүлэн дарж булсан, 368.5 га дарж булсан талбайг хөрсжүүлж ургамалжуулсан /биологийн нөхөн сэргээлт хийсэн/ байна /Зураг 2.6.6.1/.



Зураг 2.6.6.1: Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан уурхайн эдэлбэр газар, га-аар.

2019 оны мэдээгээр Дорноговь, Төв, Өмнөговь, Сэлэнгэ аймагт уурхайн эдэлбэр газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан байна.


## 2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ /МАЯГТ ГТ-8/

Улсын хэмжээнд 2019 онд Газрын төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол, ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” 187 дугаар тушаал, ГЗБГЗЗГ-ын, ТЕГ-ын хамтарсан 2019 оны “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ” 2019/09-01/32 дугаар гэрээний дагуу газрын төлбөрийг ногдуулж, төвлөрүүлж байна. Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт өссөн дүнгээр нийт **618 тэрбум 752 сая** төгрөгийг төвлөрүүлээд байна /Хүснэгт 2.7.1, Зураг 2.7.1/.

Хүснэгт 2.7.1: Газрын төлбөрийн гүйцэтгэл /он тус бүрээр/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1919.6	1524.5	80
1999	2678.6	1764.2	66
2000	3221.5	2895.0	90
2001	4673.6	5401.9	116
2002	5570.7	6163.1	110
2003	7303.4	7962.0	109
2004	11840	11795.2	99
2005	13867.6	14045.2	101
2006	14323.0	15780.7	110
2007	19786.8	20093.7	102
2008	24790.4	25543.4	102
2009	28006.6	29472.4	105

2010	29311.7	30448.6	104
2011	31280.7	33556.8	107
2012	39031.3	43623.2	112
2013	37912.0	43185.1	114
2014	42326.9	44950.9	106
2015	45712.6	44556.2	97
2016	47002.6	46940.4	99.9
2017	47683.4	49361.9	103.5
2018	48875.9	51616.9	105.6
2019	76426.8	88070.9	115.2
<b>Нийт</b>	<b>583545.7</b>	<b>618752.3</b>	




Зураг 2.7.1: Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /он тус бүрээр/

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт **88 тэрбум 7.09 сая** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө **11 тэрбум 644.12 сая** төгрөгөөр давж биелсэн бөгөөд гүйцэтгэл **115.2** хувьтай байна /Хүснэгт 2.7.2, Зураг 2.7.2, Зураг 2.7.3/.


Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 36 тэрбум 454.03 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан, Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем Улсын хэмжээнд нэвтрүүлж нэгж талбар бүрийг бүртгэсэн, Газрын үнэлгээ, татвар төлбөрийн системийг нэвтрүүлж нэгж талбар бүрт газрын төлбөрийг бүрэн ногдуулсан мөн жил ирэх бүр газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Хүснэгт 2.7.2: Аймаг, нийслэлийн 2019 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Аймаг нийслэл	Төлөвлөгөө (мян.төг)	Гүйцэтгэл (мян.төг)	Гүйцэтгэл /хувиар/
1	Архангай	60000	82071.9	136.8
2	Баянхонгор	270000	277519.1	102.8
3	Баян-Өлгий	113000	115392.9	102.1
4	Булган	238000	603721.0	253.7
5	Говь-Алтай	385225.6	366534.0	95.1
6	Говьсүмбэр	163811	223453.8	136.4
7	Дархан-Уул	845200	1061200.0	125.6
8	Дорнод	584500	631464.9	108.0
9	Дорноговь	480000	971092.2	202.3
10	Дундговь	187700	282674.6	150.6
11	Завхан	205000	207390.6	101.2
12	Орхон	14100000	20135650.8	142.8
13	Өвөрхангай	187650	296128.3	157.8
14	Өмнөговь	3615922.3	6038198.9	167.0
15	Сүхбаатар	130000	221815.7	170.6
16	Сэлэнгэ	420534	695998.1	165.5
17	Төв	1700000	2597874.5	152.8
18	Увс	155000	234878.0	151.5
19	Ховд	180000	195213.8	108.5
20	Хөвсгөл	235300	270354.0	114.9
21	Хэнтий	170000	553173.3	325.4
22	Улаанбаатар	52000000	52009161.4	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>76426842.9</b>	<b>88070961.6</b>	<b>115.2</b>




Зураг 2.7.2: Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Орхон, Өмнөговь, Төв аймаг, нийслэлээс бусад/



Зураг 2.7.3: Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Орхон, Өмнөговь, Төв аймаг, нийслэл/

2019 оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэлийг аймаг, нийслэл тус бүрээр авч үзвэл Говь-Алтай аймгаас бусад аймаг, нийслэл нь газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 100.0-325.4 хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүлсэн байна /Зураг 2.7.4/.



Зураг 2.7.4: Тайлант оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл /хувиар/

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн аймаг, нийслэлийн хувьд хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж бүрт ногдуулж, хураан барагдуулах ажлыг батлагдсан журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажиллав.

Мөн газрын төлбөрийн өрийг барагдуулах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Газар эзэмших, ашиглах гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээг дүгнэх;
- Газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, тасалдаж байгаа орлогын хэмжээг нэмэгдүүлэх, төлбөр барагдуулалтын талаарх мэдээ, газар эзэмших, ашиглах гэрээг дүгнүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас зэргээр зар сурталчилгаа явуулах;
- Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах;
- Тодорхойгүй орлогын талаар арилжааны банкуудтай хамтран ажиллах;
- Газрын төлбөрийн их хэмжээний өртэй аж ахуйн нэгж, байгууллагыг шүүхэд нэхэмжлэх гарган газрын төлбөрийг барагдуулах
- Газрын төлбөрийн мэргэжилтэн, газрын даамал нь газрын төлбөр төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад акт, шаардлага хүргүүлэх эрхгүй тул аймгийн Аудитын газартай хамтран хяналт шалгалт оруулан газрын төлбөр төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад акт тогтоолгон барагдуулах.

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй аймгуудын хувьд:

- Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг батлуулан Хууль зүйн яаманд эрхзүйн актаар бүртгүүлэх ажил удааширсан;
- Эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй зэргээр Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй газар эзэмшигч, ашиглагч нарт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгон хариуцлага тооцон холбогдох төлбөр тооцоонд хасалт хийгдсэн;
- Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоож төсөв хөрөнгө байхгүй шалтгаанаар газрын төлбөр төлөхгүй байх;
- Мал бүхий иргэд бэлчээрийн газрын төлбөрийг төлдөггүй зэрэг шалтгааны улмаас газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг тасарсан гэж үзэж байна.

2019 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот тосгон, бусад суурины газар болон тусгай хэрэгцээний газар, хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газрын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тоо бусад ангиллын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тооноос харьцангуй их байгаатай холбоотой юм /Зураг 2.7.5/.





Зураг 2.7.5: Газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт /Газрын нэгдмэл сангийн ангиллаар, хувиар/

2019 оны газрын төлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлдэг данс нэг байдагтай холбоотойгоор сум тус бүрийн газрын төлбөрийг тодорхой гаргаж, төлбөрийг нэгж талбар тус бүрээр ногдуулж барагдуулах, хэд хэдэн газартай газар эзэмшигчийн газрын төлбөрийн давхардлыг арилгах, хянах зорилгоор сар бүр газрын төлбөрийн хуулгыг боловсруулж, сумдын даамлуудтай харилцан мэдээлэл солилцож, ажлын уялдааг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудад төлбөр төлөгч иргэдийн сумын нэр, регистрийн дугаарыг давхар бичилт хийж өгөх талаар газрын даргын албан тоотыг хүргүүлэн ажиллаж байгаа ба аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтнүүдтэй тодорхойгүй орлогын талаар өдөр бүр тогтмол холбогдож, газрын төлбөр барагдуулах тооцоо нийлэх асуудлаар хамтран ажиллаж байна.

Аймгуудын зүгээс урьд оны дутуу төлөлт, газрын төлбөрийг барагдуулах төлбөрийн гүйцэтгэлийг хангахын тулд аймаг, сумын Засаг дарга, Татварын хэлтэстэй хамтран Газрын төлбөр барагдуулах тодорхой хугацааны аян зохион байгуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл, мэдээлэл явуулж ажилласан ба үүрэн телефоны корпорацитай хамтран ажиллаж, “Мобайл сурталчилгааны үйлчилгээ”-г нэвтрүүлэх гэрээ байгуулж, газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгуулагад текстэн зар хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Ингэснээр аймгийн хэмжээнд нийтийг хамарсан мессежийг /текстэн зар/ газрын төлбөр төлөгч бүрт шуурхай хүргэж, газар эзэмших гэрээний нөхцөл болзлын дагуу гэрээгээ дүгнүүлэх, урьд онуудад төлж барагдуулаагүй өр авлагыг барагдуулахад томоохон ажлуудын нэг болсон байна.

Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан нөхцөл болзлыг удаа дараа зөрчсөн тухайлбал эзэмшил газраа 2 жил дараалан хүндэтгэн үзэх шалгаангүйгээр ашиглаагүй, газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй газар эзэмшигч, ашиглагч нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу

хариуцлага хүлээлгэх мэдэгдлийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүргүүлэн ажилласан.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн газар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд газар ашигласан төлбөрийг ногдуулж, газрын төлбөрөө хугацаанд нь барагдуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад алданги /хүү торгууль/ тооцож, төсөвт төвлөрүүлсэн.

Газрын татвар, төлбөрийн системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

2019 онд Газрын татвар, төлбөрийн системийг нэвтрүүлэхээр хөгжүүлэлтийн ажлыг хийж эхэлсэн бөгөөд 21 аймагт нэвтэрсэн байна. Тус системийг нэвтрүүлэхтэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу 330 сум, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг батлуулах ажлыг зохион байгуулах;
- Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, итгэлцүүрийг Газрын төлбөр, татварын системд газар ашиглалтын зориулалт тус бүрээр оруулах;
- Газрын татвар, төлбөрийн системийг Татварын удирдлагын нэгдсэн системд холбох, турших;
- Улсын тэмдэгтийн хураамж, хураамжийн орлогыг Татварын удирдлагын систем болон Газрын төлбөр, татварын системээр дамжуулан мэдээлэл солилцох ажлыг турших;
- Газрын татвар, төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрийг газрын татвар, төлбөрт хамруулах;
- Газрын татвар, төлбөрийн урьд оны илүү, дутууг гаргах, нөхөн бүрдүүлэлт хийх зэрэг ажлуудыг хийсэн байна.

2020 оноос Газрын татвар, төлбөрийн систем нь Татварын удирдлагын нэгдсэн системтэй холбогдон бүрэн нэвтэрч газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч нь төлбөрийн мэдээллээ интернетээр, гар утас, таблет ашиглан авах, газрын татвар, төлбөрөө “Газрын татвар, төлбөрийн систем”, “Татварын удирдлагын нэгдсэн систем”, мобайл банк, гар утасны апплейкшн зэргийг ашиглан төлөх боломжтой болсон юм.

## 2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-9/

2019 оны байдлаар Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт **637501** иргэний **64317.90** га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль анх 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдаж, 2003 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн билээ.


Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-д 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд үүний 3 удаад нь гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх хугацааг тухай бүр 5 жилээр сунгасан байна.

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 4.1.1-д заасан зориулалтаар Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх тухай энэхүү хуулийн 19.1.2, 19.1.3, 19.1.4 дэх заалтыг 2028 оны 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл дагаж мөрдөхөөр өөрчлөлт орсон.

Мөн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи улсын хүн амын тоог, газар өмчлөгч иргэдийн тоотой харьцуулан үзэхэд 2009 болон 2012 онуудад тодорхой хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь газар өмчлүүлэх хугацаа дуусах үед газар өмчлөл эрчимжиж, сунгасны дараах үед нь буурч байгаа нь харагдаж байна /Хүснэгт 2.8.1, Зураг 2.8.1/.

Хүснэгт 2.8.1: Хууль хэрэгжиж эхэлснээс хойш газар өмчлөлийн байдал

№	Он	МУ-ын нийт хүн амын тоо	Газар өмчилсэн нийт иргэдийн тоо	Хувь
1	2003	2495091	21879	0.9
2	2004	2521733	63867	2.5
3	2005	2551081	135077	5.3
4	2006	2583254	152164	5.9
5	2007	2620446	174016	6.6
6	2008	2665955	222094	8.3
7	2009	2716275	203043	7.5
8	2010	2760968	255749	9.3
9	2011	2811666	255747	9.1
10	2012	2867744	330240	11.5
11	2013	2930277	371978	12.7
12	2014	2995949	418671	14.0
13	2015	3057778	446004	14.6
14	2016	3119935	537321	17.2
15	2017	3119935	570771	18.3
16	2018	3177899	615454	19.4
17	2019	3238479	637501	19.7



Зураг 2.8.1: 2003-2019 онуудын газар өмчлөлийн байдлыг иргэдийн тоотой харьцуулсан байдал

Тайлбар: 2019 оны байдлаар Монгол улсын хүн амын тоо аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэгдэж, албан ёсоор гараагүй тул өмнөх оны /2018/ тоон мэдээг ашигласан болно.

Гэр бүлийн хэрэгцээнд үнээр нь худалдаж 7.15 га газрыг 811 иргэнд, Аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж 129.5 га газрыг 281 иргэнд, Аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар 1.63 га газрыг 50 иргэнд, Газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж 60.37 га газрыг 57 иргэнд худалдаж тус тус өмчлүүлээд байна.

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж ту бүрээр харьцуулж, хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2.8.2: Үнэгүй газар өмчилж авсан иргэдийг хүн амын тоотой харьцуулсан байдал

№	Аймаг	Хүн амын тоо	Өмчилсэн иргэдийн тоо	Хүн амын газар өмчилсэн байдал /хувиар/
1	Архангай	96720	16790	17.4
2	Баян-Өлгий	105090	13131	12.5
3	Баянхонгор	88356	11654	13.2
4	Булган	62214	15094	24.3
5	Говь-Алтай	58471	7510	12.8
6	Говьсүмбэр	17796	9821	55.2
7	Дархан-Уул	105923	14016	13.2
8	Дорноговь	69304	19878	28.7
9	Дорнод	80984	39387	48.6

10	Дундговь	46628	15966	34.2
11	Завхан	72779	8890	12.2
12	Орхон	105987	20234	19.1
13	Өвөрхангай	117112	24287	20.7
14	Өмнөговь	66722	38367	57.5
15	Сүхбаатар	62322	10218	16.4
16	Сэлэнгэ	111403	45837	41.1
17	Төв	95662	67116	70.2
18	Увс	84309	10441	12.4
19	Ховд	88330	12745	14.4
20	Хөвсгөл	133964	14025	10.5
21	Хэнтий	77028	22269	28.9
22	Улаанбаатар	1491375	199825	13.4
<b>Улсын дүн</b>		<b>3238479</b>	<b>637501</b>	<b>19.7</b>

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн хүн амын тоотой харьцуулахад хамгийн их хувьтай нь Төв аймаг 70.2, Өмнөговь аймаг 57.5, Говьсүмбэр аймаг 55.2 байгаа бол хамгийн бага хувьтай нь Хөвсгөл аймаг 10.5, Завхан аймаг 12.2, Увс аймаг 12.4 байна.

Тайлант онд 22047 иргэнд 2100.56 га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс

- Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүйгээр 21641 иргэнд 2066.37 га газрыг;
- Гэр бүлийн хэрэгцээнд үнээр нь худалдаж 48 иргэнд 0.53 га газрыг;
- Аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар худалдаж 19 иргэнд 0,21 га газрыг;
- Газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж авсан 2 иргэнд 3.7 га газрыг тус тус өмчлүүлсэн байна.

2019 онд нийт газар өмчилж авсан иргэдийн тоон өсөлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр харьцуулан үзвэл Төв аймаг 10091 иргэн, Өвөрхангай аймаг 4773 иргэн, нийслэл 7539 иргэнд газар өмчлүүлсэн бол Сүхбаатар аймаг 202 иргэнд, Ховд аймаг 269 иргэнд, Баянхонгор аймаг 367 иргэнд тус тус өмчлүүлсэн дүнтэй байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “газар өмчилж авахыг хүссэн Монгол улсын иргэн сайн дурын үндсэн дээр өмчилнө” гэж заасан бөгөөд тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоохдоо аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зэрэг инженер, нийгмийн дэд бүтцийн иж бүрэн төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг нийцүүлэн боловсруулах нь чухал ач холбогдолтой юм.

## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Жил бүр сум, дүүргийн Засаг дарга 12-р сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 01-р сарын 15-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Маягт ГТ-1

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛЫН 2019 ОНЫ ТАЙЛАН

Д/д	Аймаг/нийслэл/нэр	Нийт	Ү												Хөдөө аж ахуйн дэвсгэр	Атгасан газар	Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	Үүнээс				Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар
			Балчирхийн газар			Өвч-харьрны			Зун-намрын			Үүнээс										
			Бүгд	Балчирхийн газар	Өвч-харьрны	Зун-намрын	Хадлангийн талбай	Тариалангийн газар	Үр тариа тариалсан талбай	Төмс, хүнсний ногоо тариалсан талбай	Тэжээлийн ургамал тариалсан талбай	Таримал ургамал, жимс тариалсан талбай	Үрншилсэн талбай	Өнжөөсөн талбай				Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	Мал аж ахуйн зориулалттай	Өвөлжөө, хаваржааны дээрх газар	Газар тариалангийн зориулалттай	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
1	Архангай	5531382.00	3849523.01	3737558.03	2240822.10	1496735.93	53910.00	28899.14	26806.60	1231.14	50.00	111.40	700.00	0.00	28280.90	874.94	678.88	678.88	2.00	194.06	0.00	
2	Баянхонгор	11597780.19	8881497.64	8856384.34	4274925.44	4581458.90	10662.80	2194.75	922.97	258.10	617.58	258.10	6.00	390.10	10137.40	1927.85	1841.04	1841.04	0.00	86.81	190.50	
3	Баян-Өлгий	4570489.00	3576289.46	3541049.63	1690240.77	1850808.86	12389.66	2661.95	227.00	565.77	487.90	39.10	0.00	1342.18	383.40	19804.82	498.39	485.24	0.00	19306.43		
4	Булган	4873300.00	2730821.38	2484512.61	1173202.16	1311310.45	111940.10	89187.72	41019.10	437.94	8739.00	94.158	33936.89	4113.21	25081.65	3701.70	3525.49	3473.47	94.25	81.96	16397.60	
5	Говь-Алтай	14144766.91	8621066.61	8608766.74	3507022.41	5101744.34	2633.00	5207.37	1618.45	1180.80	475.60	1592.06		340.46	541.72	3917.78	2841.00	2841.00	1047.30	29.48		
6	Говьсүмбэр	554180.00	484944.68	472602.25	189422.90	283179.35	7810.00	360.02	183.00	172.02	5.00				79.59	61.49	61.49			18.10	4092.82	
7	Дархан-Уул	3275000.00	221434.39	175538.93	79349.10	96189.83	9072.50	34222.90	9607.17	2012.24	804.70	532.85	15791.20	5474.94	103.70	2496.36	1464.76	368.81	40.76	990.84	0.00	
8	Дорноговь	10947230.00	9541461.85	9113884.45	5454066.02	3659818.43	112.00	563.31	101.20	419.61	9.00	21.00	3.00	9.50	329.30	6240.60	6189.30	5002.86	47.90	3.40	420332.20	
9	Дорнод	12359743.00	9633374.42	8655730.67	4209948.93	4445781.74	83294.08	101821.67	47981.23	462.88	161.00	1395.00	28046.00	23775.76	26002.56	10525.44	8829.61	8829.61	11.00	1684.83	0.00	
10	Дундговь	7469032.00	7152069.17	7148094.30	3636542.08	3511552.22	0.00	701.57	191.11	191.11	390.50	119.96			3260.30	2947.10	2947.10			913.20	13.00	
11	Завхан	8245566.52	6988103.77	6924747.69	3890658.24	3084089.45	6493.50	17406.45	2333.74	1006.74	11782.41	72.16	1829.00	382.40	35154.06	4302.07	4292.07	4291.67	0.00	10.00	0.00	
12	Орхон	84400.36	46264.96	39345.58	11821.38	27524.20	1404.22	5101.74	3147.00	748.93	46.06	44.05	1023.38	92.32	253.05	160.37	77.07	77.07	38.44	44.86		
13	Өвөрхангай	6289533.00	5740269.40	5689392.03	2844696.02	2844696.02	6587.23	25467.71	20029.86	1140.28	1946.63	2350.94	0.00	0.00	13733.07	5089.36	3310.88	3310.88	46.80	1731.68	0.00	
14	Өмнөговь	16538047.00	11791744.27	11430595.50	4771405.89	6659189.61	30.00	740.66	0.00	534.18	182.08	21.40	0.00	3.00	26.81	3356.30	3207.26	3207.26	1.00	148.04	356995.00	
15	Сүхбаатар	8228715.63	7746760.17	7688465.10	3002141.72	4666323.39	44488.80	17197.74	500.00	10077.84	6600.00	19.90	0.00	0.00	13933.10	2675.42	2524.10	2524.10	0.67	150.66	0.00	
16	Сэлэнгэ	4115263.00	2056709.82	1610592.87	644639.12	965953.75	123201.50	315981.81	154275.00	4846.90	21302.88	555.40	113375.01	21626.62	2834.69	4091.56	3466.75	3043.37	571.50	45.91	7.40	
17	Төв	7404237.04	5587708.96	5177266.89	2385278.40	2791988.29	63109.45	261391.24	81737.00	6669.94	12560.38	9049.00	80753.20	70621.72	37680.16	4368.72	2414.53	1186.46	754.26	1199.93	14892.70	
18	Увс	6958539.00	4822300.18	4269243.59	1675927.18	2593316.41	22005.67	77391.00	17095.00	490.89	132.10	876.26	6278.00	51329.75	2308.86	4665.06	3983.02	3525.16	589.27	92.77	446686.00	
19	Ховд	7606038.00	5092290.14	5058670.27	3129153.14	1929517.13	17998.58	9890.11	1673.93	3390.87	1866.93	577.26		2381.12	2500.06	3223.52	2840.66	2840.66	30.00	352.86	7.60	
20	Хөвсгөл	10062882.01	4479340.70	4386177.13	2061796.77	2324380.37	44359.70	32736.17	17415.81	2040.83	1173.44	284.77	11297.23	524.09	8118.90	7826.60	7260.07	7260.07	0.00	568.53	122.20	
21	Хэнтий	8032506.00	5468103.58	5067071.20	1895536.25	3171534.96	325997.68	80257.35	19171.00	595.80	8345.40	474.29	23530.46	28140.40	6210.60	8566.75	8150.35	8150.35	87.40	323.00	0.00	
22	Нийслэл	470444.00	233599.65	214887.96	83459.57	131428.40	5582.00	7860.68	0.00	5944.27	444.79	1327.12	0.00	144.50	2939.75	2329.26	2025.39	72.40	12.66	291.21	0.00	
	НИЙТ ДУН	156411574.66	114736678.23	110330577.57	52852055.56	57478522.01	1709082.47	1117243.06	444739.09	45094.73	79312.38	20835.42	316569.38	210692.07	216553.74	103484.36	71829.19	65418.93	3375.20	28272.57	1259737.02	

д/д	Х о т т о с г о н, б у с а д с у у р и н ы г а з а р																						
	Бүгд		Үүнээс			Үүнээс			Үүнээс			Үүнээс		Үүнээс		Үүнээс		Үүнээс		Үүнээс		Үүнээс	
	Барилга, байгууллагын дэвсгэр газар, бүгд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөд, азамшил, ашиглалтад байгаа барилга, газар	Амралт, рашаан сувиллын газар	Нийтийн аялалт, үйлдвэрийн газар, бүгд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын азамшил, бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай болон цэцэрлэг хүрээлэнгийн газар	Гудамж, талбай, замны газар	Цэвэрлэх байгууллагын талбай	Ошуулгын газар	Хор хаягдлын газар	Эзэмшил, ашиглалтад орлоогүй сул чөлөөтэй газар	Үйлдвэрийн газар	Уурхайн дэвсгэр газар	Үүнээс		Үүнээс		Үүнээс		Үүнээс		Үүнээс	Үүнээс	
	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40					
0	22																						
1	14811.04		1054.99	1985.52	34.38	288.60	5.00	114.10	39.50	1503.94	44.20	9788.00	9788.00	5.20	14.80	1760.42	1560.73	199.69					
2	27575.15		715.09	6213.85	69.92	705.50	121.00	536.80	200.70	4579.93	60.88	19545.56	18660.97	3.25	881.34	999.77	999.73	0.04					
3	16058.07		664.23	13056.75	42.88	424.14	11.90	254.71	157.71	12165.41	101.94	0.00				2228.81	2145.18	83.63					
4	33140.93		2510.17	21635.94	614.38	1291.07	334.80	221.80	277.48	18896.40	239.28	6129.28	6067.44	24.08	37.76	2200.73	2198.23	2.50					
5	18165.04		883.52	11475.93	41.90	2316.60	17.20	299.00	280.50	8520.73	2.40	2284.07	1503.28	756.15	24.64	977.54	964.60	12.94					
6	6662.82		1877.30	2029.17	0.50	101.96		4.75	180.35	1741.61	747.65	745.00	475.80	269.20		1212.15	1212.15	0.00					
7	19712.80		1116.25	5595.31	49.41	1443.24	29.99	82.92	290.10	3699.65	1880.89	9071.65	9061.12	8.10	2.43	1680.10	1677.90	2.20					
8	165668.06		1957.49	13428.64	53.66	93.36	35.05	184.87	72.19	12989.51	8932.44	137948.72	137529.19	179.03	240.49	3347.79	3323.04	24.75					
9	89050.63		509.23	53589.43	34.03	123.72	65.82	178.39	326.50	52840.97	422.96	30107.09	13034.67	1452.07	15620.35	4324.51	4120.17	204.34					
10	19811.56		341.57	7618.62	53.21	987.80	32.30	91.80	191.00	6262.51	9.64	10380.18	9613.46	694.72	72.00	1400.00	1394.90	5.10					
11	20452.11		174.86	13753.05	59.70	778.80	16.60	141.20	172.70	12584.05	67.40	4569.40	4388.40	155.00	46.00	1827.00	1809.00	18.00					
12	20713.88		1043.57	13560.32	447.40	46.70	7408.82	30.00	90.30	5537.10	458.09	4000.19	916.00	1307.69	1776.50	1611.57	1606.15	5.42					
13	46371.34		449.35	29758.73	51.17	5.06	72.89	43.28	101.62	29484.71	129.93	13645.41	13637.81	4.60	3.00	2323.47	2322.67	0.80					
14	54606.32		1121.91	900.99	82.97	353.74	14.50	46.50	192.60	210.67	16096.69	32877.01	21979.46	10368.30	529.25	3423.77	3423.77	0.00					
15	21184.23		155.10	12530.99	37.68	43.07	0.77	189.71	480.15	11779.61	136.57	7634.82	5742.87	1891.95	0.00	646.51	646.51	0.00					
16	64105.11		1992.13	20645.12	132.64	427.81	32.11	116.40	99.00	19837.16	7757.70	24064.81	23832.79	64.72	167.30	8969.75	7515.34	1454.41					
17	92250.47		7066.61	15268.11	778.66	1653.36	88.75	502.90	181.70	12062.74	803.61	50120.43	49558.32	205.60	356.51	13008.09	12754.80	253.29					
18	16827.69		454.10	7710.40	37.33	540.29	7.30	105.80	166.12	6853.56	173.04	3408.99	3360.16	24.23	24.60	1800.44	1411.54	388.90					
19	35405.27		2350.42	28787.84	922.13	343.31	9.60	211.70	380.30	26920.80	1220.40	260.00	255.70	2.00	2.30	2755.27	2469.47	285.80					
20	19397.16		1836.72	12911.20	2985.55	2088.57	16.60	138.80	158.00	7523.68	303.88	1001.30	993.80	7.00	0.50	3192.48	2549.83	642.65					
21	32983.73		776.94	26539.40	221.49	3001.13	47.50	259.70	2310.60	20698.98	194.26	2769.37	2685.17	64.20	20.00	2458.97	2234.87	224.10					
22	71853.93		35133.26	3141.74	611.01	706.35	182.01	361.24	52.75	1228.38	6186.89	5480.55	4840.98	639.57	0.00	20657.07	20456.62	200.45					
	906807.34		64184.21	322117.04	7362.00	17764.20	8550.51	4116.37	6401.87	277922.10	45970.74	375831.83	337885.39	18126.66	19819.77	82806.19	78797.18	4009.01					

д/д		З а м, ш у г а м и с ү л ж э з н и й г а з а р																					
		Үүнэс				Үүнэс				Үүнэс													
Бүт		Авто замын газар	Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	Авто тээврийн барилга, байгууламж, зосмоолын талбай	Төмөр замын газар	Төмөр замын далангийн талбай, хамгаалтын зурвас газар	Өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн талбай	Агаарын тээврийн газар	Нислэгийн аюулийг байдлыг хамгаалах бүсийн газар	Барилга байгууламж, төхөөрөмжийн газар	Шугам сүлжээний газар, бүтд	Холбооны шугам, холбооны авах станцын зэрлэх талбай	Эрчим хүчний шугам, станцын зэрлэх талбай	Үс, дулаан дамжуулах хоолойн зэрлэх талбай	Үс шахах, өргөх байгууламжийн доорхи газар	Үерээс хамгаалах далан, сувгийн зэрлэх талбай	Үс тээврийн газар, бүтд				
0	41	7122.96	3775.55	0.00	3770.55	44	44	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59
1		8067.52	4744.86	1054.98	3643.60	44.20	2.08	0.00	5.00	0.00	0.00	30.00	29.50	52	53	3317.40	1904.40	1370.00	40.00	3.00	0.00		
2		14833.79	13359.13	236.50	13121.52	1.11	0.00	0.00	59.10	56.30	0.80	3263.56	1107.57	2072.49	47.00	36.50							
3		7831.71	2969.41	865.69	2033.10	55.00	15.62	0.00	143.00	186.80	1.26	4707.30	1862.15	2590.40	181.79	28.11	44.85						
4		7643.13	4863.00	434.50	4378.00	48.10	2.40	0.00	188.06	186.80	1.26	2592.07	722.77	1837.30	25.00	2.00	5.00						
5		5192.54	2128.55	747.30	1317.60	63.60	0.05	1358.99	1165.16	193.83	0.00	1705.00	351.76	1395.71	12.97	4.56							
6		6175.98	3409.37	703.38	1121.95	1583.30	0.74	1493.26	1469.07	24.19	0.00	1273.25	53.35	1118.46	12.84	51.46	37.14						
7		6072.12	3558.97	5463.07	28844.43	1103.19	178.29	11086.18	10998.88	87.30	3580.00	3577.00	3.00	10466.97	2584.28	7327.57	574.99	7327.57	574.99	28.60	229.10	9.60	
8		50733.36	40206.11	5298.00	34234.51	270.20	463.40	5044.60	4997.30	47.30	667.60	495.80	171.80	4815.05	1530.94	3016.81	28.60	248.20	3.00				
9		31266.46	25731.80	2410.50	20778.00	2538.00	5.30	480.00	465.00	15.00	46.70	45.00	1.70	5007.96	2023.17	2670.39	63.20	808.40	762.45	2.00	0.00	0.00	
10		6584.27	4920.42	193.90	4139.60	586.92	0.00	91.00	83.00	8.00	0.00	0.00	0.00	494.66	55.14	425.97	11.52	2.03					
11		1169.44	257.46	87.70	149.66	20.10	0.00	417.32	306.69	110.63	0.00	266.01	265.10	0.91	6360.13	2635.86	3392.15	28.70	17.22	286.20			
12		24745.38	18119.24	1814.90	16053.69	249.71	0.94	2428.88	2292.54	136.34	78.08	78.08	0.00	6373.19	755.65	5193.64	294.71	78.08	51.10				
13		28049.70	13887.09	1425.90	8839.65	3318.65	302.89	2128.60	1978.60	150.00	878.48	876.03	2.45	11155.53	1296.92	4096.17	5656.40	56.47	47.57	0.00			
14		15357.34	7787.35	2.10	7751.90	33.20	0.14	0.00	148.20	148.10	0.10	7421.79	2202.15	5195.12	1.71	22.42	0.39	0.00					
15		22207.13	13326.98	2508.10	7715.31	3083.76	9.81	2428.88	2292.54	136.34	78.08	78.08	0.00	6373.19	755.65	5193.64	294.71	78.08	51.10				
16		54082.05	42495.18	17015.20	23084.48	2381.40	14.10	3689.59	3597.59	72.00	1200.00	1200.00	0.00	6717.28	1987.76	4583.38	138.44	2.00	27.20				
17		46160.06	41220.66	10140.00	30561.53	518.30	0.83	0.00	333.17	331.67	1.50	4606.23	1643.21	2933.52	0.00	2.30	36.85						
18		27468.52	24691.16	5919.00	18767.29	2.47	2.40	0.00	355.00	175.40	179.60	2422.36	860.00	1408.97	79.16	37.38	36.85						
19		8439.16	4041.82	1053.60	2772.82	213.00	2.40	0.00	142.05	140.50	1.55	4253.29	773.95	3472.42	5.62	0.00	1.30	2.00					
20		34588.49	29126.34	6816.80	21073.24	1157.30	79.00	213.00	86.00	66.00	18.00	5163.15	1888.30	3053.35	186.20	15.00	20.30	0.00					
21		6310.92	1191.62	555.00	556.88	52.92	26.82	1355.87	1290.27	65.60	895.60	436.00	459.60	2867.83	832.83	1773.06	138.44	60.85	62.65	0.00			
22		474751.93	337842.07	64686.12	254709.31	17334.42	1112.21	29767.29	28857.10	910.19	9109.05	8254.28	854.77	98031.51	28401.41	59590.22	9554.79	917.25	675.42	2.00			





Улсын тусгай хэрэгцээний газар										
Үүнээс										
Улсын хилийн зурвас газар	Улсын бөтгөл хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	Гадаадад улсын дипломат төлөөлчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлчийн газарт олгосон газар	Цинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон бэлтгэл ажиглалтын талбай	Аймаг дундын отрын бэлчээр	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	Бүтэцгүйн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	Чөлөөт бүсийн газар	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дад бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	Аюултай хор хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	
77	78	79	80	81	82	83	84			
0.00	0.00	0.00	26.00	0.00	0.00	0.00	0.00			
74500.00	168.65	0.00	30.00	51860.00	0.00	0.00	0.00			
53935.00	2673.04	0.00	0.00	8000.00	0.00	0.00	708.40	10350.25		
79164.00	5887.49	0.00	3.00	26989.00	9520.00	0.00	0.00			
315705.00	406.20	0.00	8250.63	0.00	0.00	0.00	0.00			
0.00	767.16	0.00	1.00	55073.80	0.00	0.00	0.00			
0.00	18.23	1.90	1457.20	0.00	0.00	0.00	0.00			
299000.00	6372.10	0.00	6293.15	0.00	0.00	23400.00	900.00	400		
643931.40	4837.12	2.00	6072.02	124400.00	0.00	1070.00	0.00			
0.00	89.03	0.00	14.00	0.00	0.00	0.00	0.00			
8950.00	195.51	0.00	72.00	66300.00	0.00	0.00	0.00			
0.00	140.28	1.80	0.40	0.00	0.00	0.00	0.00			
0.00	31717.96	0.00	77.00	20282.00	0.00	0.00	0.00			
396100.00	7048.70	0.00	62.70	0.00	0.00	0.00	0.00			
188000.00	1774.91	0.00	55.90	0.00	23000.00	0.00	0.00			
173822.00	1814.39	0.00	347.71	0.00	66279.00	0.00	500.00			
0.00	42817.48	0.00	13163.84	24786.00	0.00	0.00	0.00			
141294.54	936.42	0.00	24.00	20900.00	9941.00	0.00	0.00	12243.37		
155000.00	8467.05	0.00	60.00	105200.00	2200.00	0.00	0.00	5406.38		
441000.00	418.23	0.00	33.80	0.00	0.00	0.00	0.00			
141593.00	114.28	0.00	24.00	185623.00	0.00	0.00	0.00			
0.00	7433.38	28.12	57.28	0.00	0.00	0.00	0.00			
<b>3111994.94</b>	<b>124097.61</b>	<b>33.82</b>	<b>36125.64</b>	<b>691413.80</b>	<b>110940.00</b>	<b>24470.00</b>	<b>2108.40</b>	<b>28400.00</b>	<b>32.00</b>	



		Г о т т о с г о н, б у с а д н э с у у р и н ы г а з а р																	
		У н э э с																	
д/д	Бүгд	У н э э с																	
		Барилга, байгууламжийн дэвсгэр газар, бүгд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, эмчлэлт, ашиглагдаж байгаа барилга, байгууламжийн дэвсгэр газар	Амралт, рашаан сувиллын газар	Нийтийн адалбарийн газар, бүгд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил бүс амралт, зуагаар, биений тамирын зориулалттай болон	Гудамж, талбай, замын газар	Цэвэрлэх байгууламжийн талбай	Оршуулгын газар	Хор хаягдлын газар	Эзэмшил, ашиглагдаж олгодоггүй сул чөлөөтэй газар	Үндэврийн газар	Уурхайн дэвсгэр газар	Ашигт малтмал олоорлох байгаа уурхайн талбай	Үндэвэрлэлийн зориулалттай барилга, байгууламжийн газар	Сурьшлын бүсийн барилга, байгууламжийн газар	Гаг хорооллын газар, бүгд	Гаг, орон сууцны хашааны газар	Гаг бүлийн хэрэгцээний төмс, хуучин ногооны талбай
0	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34
	63761.53	0.00	0.00	0.00	0.17	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.17	0.00	0.00	0.00	0.00	0.00	63761.36	63738.08	23.28
	29.27	20.41	20.41	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	8.87	8.87	0.00
	30598.05	10562.69	7562.73	2999.96	136.98	114.31	0.28	0.00	12.00	5.00	7.39	1038.47	226.69	130.40	73.63	22.65	18631.23	16370.84	2260.39
	78513.19	18232.41	17302.35	930.06	57083.82	1591.21	517.57	175.48	904.59	701.34	53193.62	1682.16	1322.65	1066.81	203.36	52.48	192.15	174.57	17.68
	219233.00	27215.22	20608.26	6606.96	390.15	132.61	8.34	81.35	156.54	9.03	2.28	35716.46	154900.97	143131.51	10180.03	1589.43	1010.20	503.93	506.27
